

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗРЫН 2018 ОНЫ ЭХНИЙ 9 САРЫН ЯВЦ ХЭРЭГЖИЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2018 оны 09 дүгээр сарын 29
Дуурсах

Тус Цагдаагийн газар нь 2018 оны эхний 9 сард аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд Цагдаагийн байгууллагаас дэвшүүлсэн зорилт, хүрэх Түшигийн шалгуур үзүүлэлтийг хангах, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны стандартыг хэрэгжүүлэх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох ажлын үр нөлөөг сайжруулах, алба хаагчдын албаны шуурхай байдал, ажлын хариуцлага, сахилга бат, харилцааны соёлыг дээшлүүлэх, иргэдийн амгалан тайван ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, иргэдийг чирэгдүүлэхгүй түргэн шуурхай үйлчлэх, албаны бэлэн байдал, мэргэжлийн ур чадвараа сайжруулах, Монгол Улсын Үндсэн хууль, Цагдаагийн албаны тухай хууль, бусад хууль, тушаал заавруудыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэгжүүлэхэд анхаарч удирдлага, зохион байгуулалтын үйл ажиллагаагаа чиглүүлэн ажилласан.

Нэг.Удирдлага, зохион байгуулалтын талаар

Цагдаагийн байгууллагаас 2018 онд дэвшүүлсэн зорилтыг мөрдлөг болгон, “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам”, “Цагдаагийн байгууллагын үйлчилгээний стандарт”-ыг хэрэгжүүлэн Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын их хурал, Засгийн газраас гаргасан Цагдаагийн байгууллагатай холбоотой үүрэг, даалгавар, шийдвэрүүдийг тасгийн дарга, ахлах байцаагч болон бие бүрэлдэхүүнд цаг тухай бүрт нь хүргэж, шаардлагатай тохиолдолд үүрэг даалгавар, шийдвэрийн талаар сургалт зохион байгуулан Цагдаагийн байгууллагад холбогдох үндэсний хөтөлбөр, дээд газраас өгсөн үүрэг, даалгавар, шийдвэрүүдийг хэрэгжүүлэх чиглэлээр тус бүр 5-32 заалт бүхий ажил, арга хэмжээний төлөвлөгөөнүүдийг тус тус гарган, биелэлтийг тооцон тогтоосон хугацаанд Цагдаагийн ерөнхий газрын холбогдох албадад хүргүүлэн ажилласан.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2018 оны 02 дугаар сарын 14-ний өдөр өгсөн үүрэг, ажлын чиглэл, тэргүүн дэд дарга, дэд дарга нараас алба хаагчдын сахилга, ажлын хариуцлагыг сайжруулах чиглэлээр ирүүлсэн 2018 оны 4/1237, 4/1708, 5/49, 5/60, 5/78 тоот албан бичгээр ирүүлсэн ажлын чиглэл, үүргийг хэрэгжүүлэх зорилгоор тус бүр 5-16 заалт арга хэмжээ бүхий ажлын төлөвлөгөөнүүдийг тус тус гарган, биелэлтийг эхний 9 сарын байдлаар тооцон холбогдох албадад хүргүүлсэн.

Аймгийн нийгэм, эдийн засгийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгагдсан Цагдаагийн газарт хамаарах болон аймгийн Засаг даргаас Цагдаагийн газрын даргатай байгуулсан үр дүнгийн гэрээнд тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх чиглэлээр 5-21 заалт бүхий төлөвлөгөө гарган батлуулж, байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тодорхой ажил арга хэмжээг төлөвлөн биелэлтийг хангуулан, үр дүнг тооцон ажилласан.

Тайлант хугацаанд газрын даргын зөвлөл 17 удаа хуралдаж үйл ажиллагааны чиглэлээр 32, хүний нөөцийн чиглэлээр 36, алба хаагчдын сахилга хариуцлагын талаар 38, нийт 106 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн.

Зөвлөлийн хурлаас гарсан шийдвэрийн дагуу албан тушаал дэвшүүлэх 5, мөнгөн урамшил олгуулах 5, шилжүүлэх 10, албанаас халах 3, ахлагчийн сул орон тоонд томилуулах зөвшөөрөл авах 3, албан тушаал өөрчлөх 10, тэтгэвэр гаргах 8, Хууль зүйн яамны шагналаар шагнуулах 6, ЦЕГ-ын шагналаар шагнуулах 14, “Албаны төлөө I, II, III” зэргийн медалиар шагнуулах 12, бүтэц орон тоонд өөрчлөлт оруулах 2, хугацааны цол олгуулах 40, офицерын дамжааны сургалтад хамруулах 2, нийт 96 алба хаагчийн материалыг харъяа албадаар нь дамжуулан шийдвэрлүүлсэн.

.Тус газрын удирдлагын үйл ажиллагааг баримтжуулан газрын даргын тушаал 189, ирсэн албан бичиг 2225, үүнээс хугацаатай 840, явуулсан албан бичиг 3213 боловсруулан баталгаажуулсан..

2017 онд хөтлөгдсөн баримт бичгүүдийг хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу тасаг, албадаас авч нэгтгэхэд нийт 960 хадгаламжийн нэгжийг хүлээн авч, байгууллагын архивт байршуулаллаа.

ЦЕГ-ын даргын 2018 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн А/50 дугаар тушаалаар хэсгийн байцаагчийн нэг орон тоог “Шаргалжуут” тосгон дахь хэсгийн байцаагч, мөн даргын 2018 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн Б/56 дугаар тушаалаар Мөрдөн байцаах тасгийн цагдаагийн орон тоог мөрдөгч, мөн даргын 2018 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн А/117 дугаар тушаалаар Цагдаагийн газрын албан тушаал, орон тоо, цол, цалингийн зэрэглэл”-ийн 6.7-д заасан багийн цагдаагийн 4 ороон тооны 1 орон тоог “Хэрэг бүртгэх тасгийн мөрдөгч, цагдаагийн ахмад, ТТ-9”, ЦЕГ-ын даргын 2018 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн а/50 дугаар тушаалаар Шүүх шүүгчийн аюулгүй байдлыг хангах ажил хариуцсан ахлах байцаагчийн орон тоог “Шуурхай удирдлагын тасгийн даргын албан тушаалд шилжүүлэн тус тус өөрчилсөн.

Тус газрын сул орон тоог нөхөх нөөц бүрдүүлэх зорилгоор хэв журмын цагдаа, цагдаа-жолоочийн орон тоог нээлттэй зарлуулах захиалгыг 2018 оны 01 дүгээр сард ЦЕГ-ын Хүний нөөцийн хэлтэст хүргүүлж, Төрийн албаны зөвлөлийн Цагдаагийн ерөнхий газрын дэргэдэх Салбар зөвлөлөөс цагдаагийн байгууллагын төрийн тусгай албан тушаалын сул орон тоог иргэдээс өрсөлдүүлэн шалгаруулах замаар нөхөх мэргэшлийн шалгалтад дээрх зарлагдсан орон тоонд өрсөлдөх хүсэлт гаргасан 23 иргэний материалыг хүлээн авч холбогдох хүний нөөцийн судалгааг явуулан, Цагдаагийн албаны тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.2, ЦЕГ-ын даргын 2015 оны А/79 дүгээр тушаалаар батлагдсан “Албан тушаалд томилох, болзол, шаардлага, шалгуур” /код 901/-д заасан болзол шаардлагыг хангасан 21 иргэний материалыг журмын дагуу бүрдүүлж, ЦЕГ-ын ХНХ-т хүргүүлж, Төрийн албаны зөвлөлийн 2010 оны 20 дугаар тогтоолоор батлагдсан “Цагдаагийн байгууллагын тусгай албан тушаалд анх орох иргэнээс мэргэшлийн шалгалт авах журам”-ын дагуу ахлагчийн сул орон тоонд өрсөлдүүлэн сонгон авах мэргэшлийн шалгалтад хамруулсан.

Байгууллагын хүний нөөцийн ил тод байдлыг ханган тус газрын сул орон тоонд өрсөлдөх иргэдийг бүртгэх, нөөцөд авах талаар аймгийн “Мазаалай” телевизээр зарыг явуулж, мөн газрын иргэдийн хүлээлгийн танхимд байрлах

байгууллагын ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн дагуу хийгдсэн мэдээллийн самбар, байгууллагын вэб сайт болон албан ёсны фэйсбүүк хаягаар зарлан мэдээлж сул орон тооны сонгон шалгаруулалтад оролцох иргэдийн нөөцийг ил тод байдлаар бүрдүүлэн “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам”/код 901/-д заасны заасны дагуу судалгааг хийн ажиллаа.

Алба хаагчдыг дэвшүүлэн томилох, гадаад, дотоодод суралцуулах, шагнал урамшуулалд тодорхойлохдоо Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам /код 909, 924/-д заасан үндэслэл журмын баримтлан сахилга ёс зүйн зөрчил гаргасан байдал, үр дүнгийн гэрээгээр хүлээсэн үүрэг, ажлын байрны тодорхойлолтод заасан зорилго, зорилтоо хэрхэн гүйцэтгэж байгаа байдлыг харгалзан шалгуур үзүүлэлт болгон газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэж хэвшсэн.

Тус газраас 2017 онд ажлын үзүүлэлтээрээ А, В үнэлэгдэн, 2018 онд албан тушаал дэвшүүлэх нөөцөд бүртгэгдэх хүсэлт гаргасан болон болзол шаардлагыг хангасан 22 алба хаагчийг нөөцөд бүртгүүлэх боломжтой эсэхийг “Албан тушаал дэвшүүлэх” /код 909/, “Хүний нөөцийн бодлогын баримт бичиг”-т заасны дагуу судлан шаардлага хангасан ахлагчаас офицерын бүрэлдэхүүнд дэвшүүлэх нөөцөд авах 12, ахлах, тасаг, хэсэг, хэлтсийн даргын нөөцөд авах 10 алба хаагчдын материалыг, холбогдох судалгааны хамт, харъяалах албадад нь хүргүүлсэн. Энэ хугацаанд сахилгын, ёс зүйн зөрчил, дутагдалгүй ажилласан 4 алба хаагчийг ахлагчаас офицерын бүрэлдэхүүнд, 2 алба хаагчийг ахлахын албан тушаалд дэвшүүлсэн томилуулсан.

Монгол улсын Засгийн газрын 2017 оны 01 тоот албан даалгавар, “Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай”, Засгийн газрын 2018 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн 258 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор Баянхонгор аймгийн Засаг даргын 2018 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн А/622 дугаар захирамж, Цагдаагийн газрын даргын 2018 оны 9 дүгээр сарын 06-ний өдрийн А/165 дугаар тушаалын дагуу Баянхонгор аймгийн сумдын Засаг даргын тамгын газар түүний харьяа төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд 2018 оны 9 дүгээр сарын 07-ноос 09 дүгээр сарын 12-ний өдөр хүртэл хугацаанд хяналт шалгалтыг Баянхонгор аймгийн хэмжээнд зохион байгуулж ажилласан.

Тус газраас ЦЕГ-ын даргын 2017 оны А/122 дугаар тушаалаар батлагдсан “Олон нийтийн цагдаагийн дүрэм”-ийг хэрэгжүүлэх чиглэлээр Цагдаагийн газрын даргын 2018 оны А/22 дугаар тушаалаар олон нийтийн цагдаа нараас тухайн ажилд тавигдах шаардлага хангаж байгаа эсэхийг шалгаж, сургалтад хамруулах ажлын хэсгийг байгуулан шалгалт, сургалтад хамруулан Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/122 дугаар батлагдсан “Олон нийтийн цагдаагийн дүрэм”-ийн 3.1-д заасан шаардлага хангаагүй, 3.3-д заасан сургалтад хамрагдаж, тэнцээгүй, ажлын үр дүн хангалтгүй үнэлэгдсэн 4 иргэний гэрээг цуцлан, олон нийтийн цагдаагаар ажиллах хүсэлт гаргасан 37 иргэдийн дунд газрын даргын 2018 оны А/14 дүгээр тушаалаар олон нийтийн цагдаагийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулах ажлын хэсгийг байгуулж, сургалтад хамрагдаж тэнцсэн 16 иргэнд гэрчилгээ олгон, тухайн сум, багийн Засаг даргын саналыг үндэслэн томилж, Олон нийтийн цагдаатай байгуулах хөдөлмөрийн гэрээ байгуулан ажилласан.

Байгууллага, алба хаагчийн өдөр тутмын үйл ажиллагаанд дотоодын хяналтыг тавих, шинэчлэн батлагдсан хууль, дүрэм, журамд нийцүүлэн цагдаагийн албан хаагчийн ёс зүйн шаардлага, хүний эрх, эрх чөлөөг зөрчих явдлыг таслан зогсоох зорилгоор байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам”-ыг шинэчлэн баталсан.

Цагдаагийн албаны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор 13 заалт бүхий ажлын төлөвлөгөө гарган даргын зөвлөлийн гишүүнээр ахлуулсан ажлын хэсгээс бүх сумдын хэсгийн төлөөлөгч, цагдаа нарын ажлыг шалган зааварчлах, тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, сумдын иргэдэд Цагдаагийн газрын 2017 оны үйл ажиллагааны тайланг тайлагнах чиглэлээр батлагдсан төлөвлөгөөний дагуу 18 суманд ажилласан.

Монгол улсын хууль зүйн яам, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Цагдаагийн Ерөнхий газар хамтран зохион байгуулсан “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд анхаарах асуудал” сэдэвт үндэсний 2 дугаар чуулганд алба хариуцсан мэргэжилтнийг хамруулсан. Мөн Цагдаагийн ерөнхий газрын даргын 2018 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн А/46 дугаар тушаалаар батлагдсан “Цагдаа дотоодын цэргийн алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх 2018 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөө”-ний дагуу Өвөрхангай аймгийн Цагдаагийн газраас “Хангайн бүсийн сургалт дадлагын төв”-д зохион байгуулсан “Гэр бүлийн хүчирхийлэл, түүнтэй тэмцэхэд анхаарах асуудал” 3 өдрийн сэдэвт модуль сургалтад 3 алба хаагчийг хамруулж, тус газраас “Гэр бүлийн хүчирхийллийн дуудлага мэдээллийг хүлээн авч, шалган шийдвэрлэх ажиллагаа” сэдвээр сургалт зохион байгуулсан.

Тус газраас аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 29 хамтарсан багийн гишүүдийг чадваржуулах чиглэлээр “Хариуцлагатай хамтарсан баг” 3 дугаар чуулганыг аймгийн Гэр бүл хүүхэд залуучуудын газартай хамтран 3 дахь жилдээ амжилттай зохион байгуулж, хамтарсан багийн гишүүн хэсгийн төлөөлөгч, хэсгийн байцаагч, олон нийтийн цагдаа нарыг хамруулан ажилласан. Мөн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, “Монгол өрх” сэтгэл зүйн хүрээлэнтэй хамтран хамтарсан багийн гишүүдийг чадваржуулах чиглэлээр “Архины хамааралтай иргэн, Архины хамааралтай гэр бүлтэй хэрхэн ажиллах” вэ? 5 өдрийн модуль сургалтыг зохион байгуулж, хамтарсан багийн гишүүдийн төлөөллийг чадваржуулж, гэрчилгээ олгож ажилласан.

Монголын эмэгтэйчүүдийн сангаас санаачлан Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамтай хамтран Хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлж, хамгаалах талаар олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, сургуулийн өмнөх боловсролын байгууллагад хүүхдийг хүчирхийллээс хамгаалах мэдлэг олгох тогтолцоог бий болгох зорилгоор 3 аймаг, 9 дүүргийн 11 цэцэрлэг дээр хэрэгжүүлж буй “Бага насны хүүхдийн хүчирхийллээс ангид байх орчинг дэмжих нь” төслийн хүрээнд тус газрын Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил хариуцсан ахлах мэргэжилтэн сургагч багшаар бэлтгэгдэн Баянхонгор сумын 10 дугаар цэцэрлэг, Богд сумын цэцэрлэгийн багш нарт 2 өдрийн, 10 дугаар цэцэрлэгийн ажилчдад 1 өдрийн сургалт зохион байгуулсан.

Хүүхдийг эрүүл аюулгүй орчинд амьдрах, сурч боловсрох, хөгжих, хамгаалуулах, нийгмийн амьдралд оролцох эрхийг хангах, хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлж, хүүхдэд ээлтэй орчныг бүрдүүлэх зорилгоор аймгийн

Нийгмийн бодлогын хэлтэс, Эрүүл мэндийн газар, Боловсрол, соёл урлагийн газар, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газартай хамтран “Хүүхэд ээлтэй орон нутаг дэд хөтөлбөр”-ийг боловсруулан ажлын хэсгээс төрийн байгууллагууд, аж ахуй нэгж, салбар бүрийн төлөөлөл, 9 баг, 3 сумын нийт 1300 иргэдийн дунд нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулж иргэдээс санал авч ажилласан ба аймгийн Засаг даргын 2018 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн “Хүүхэд ээлтэй орон нутаг” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх салбар дундын хамтын ажиллагааны баг томилох тухай А/436 дугаар захирамж гаргуулан хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг гарган хамтран ажиллаж байна.

Насанд хүрээгүй хүүхэд болон Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг гэмт хэрэг зөрчилд холбогдох, өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх чиглэлээр Ерөнхий боловсролын Эрдэм сургууль дээр Хүүхэд ээлтэй орон нутаг дэд хөтөлбөрийн хүрээнд “Тэгш хамруулсан олон нийтийн оролцоот сургууль төсөл” хэрэгжүүлэн тус сургуультай 2018 оны 03 дугаар сарын 01-ний өдөр Хамтран ажиллах санамж бичиг байгуулан ажилласан.

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлд аймгийн хэмжээнд сүүлийн 5 жилийн хугацаанд үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн мэдээллийг танилцуулж, шалтгаан нөхцөлийг судлах зорилгоор мэргэжлийн багаар дүгнэлт гаргуулахад шаардлагатай 10.000.000 төгрөгийн хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлж, 2018 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр “Монголын “Эрх зүйн хэлэлцүүлэг сэтгүүл” хэвлэл, мэдээллийн хэрэгслийн захирал Б.Гүн-билэгтэй гэмт хэрэг, зөрчлийн сүүлийн 5 жилийн гаралтын байдалд дүн шинжилгээ хийлгэхээр хамтран ажиллах гэрээг байгуулан, судалгааны ажил хийгдэж урьдчилсан байдлаар Цагдаагийн газар болон аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хуралд хянуулахаар ирүүлсний дагуу засвар оруулан, буцаан хүргүүлж, хэвлэлтэд өгүүлсэн. Мөн байгууллагын хэмжээнд сар бүр криминологи судалгааны баг хуралдаж гэмт хэрэг, зөрчил ихээр үйлдэгдэж байгаа газруудыг эргүүлийн чиглэл маршрутад оруулан, урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах талаар үүрэг чиглэлийг холбогдох албан тушаалтанд хүргүүлсэн.

Аймгийн хэмжээнд үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, зөрчлийг шуурхай илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх чиглэлээр хамтран ажилладаг тусгайлсан чиг үүрэг бүхий хууль хяналтын болон төрийн захиргааны 12 байгууллагуудтай хамтран ажиллах “Санамж бичиг” байгуулж, төлөвлөгөө гаргаж ажилласан.

Мэргэжлийн хяналтын газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Цагдаагийн газраас хамтран 2018 оны 01 дүгээр сарын 15-ны өдрөөс 2018 оны 02 дугаар сарын 15-ны өдөр хүртэл 30 хоногийн хугацаатай Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.1, 7.2.2, 7.3.1, 7.4 дэх заалтын хэрэгжилтийг хангах, хүүхэд залуучууд, олон нийтэд нөлөөллийн ажлыг өрнүүлэн “Хуулиа мөрдье-21” арга хэмжээний хүрээнд 24 заалт бүхий төлөвлөгөөг боловсруулан батлуулж ажилласан.

Аймгийн хэмжээнд архи, согтууруулах ундаа худалдан борлуулдаг, үйлчилдэг нийт 115 аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагааг шалгаж, хугацаатай албан мэдэгдэл өгч, хариуг хугацаанд нь авсан.

Аяны хүрээнд 115 аж ахуй нэгж, байгууллага, 27 ерөнхий боловсролын сургууль, их, дээд сургууль, поле техникийн коллежид Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийг сурталчилсан 1600 ширхэг зурагт хуудсыг бэлтгэн тарааж, иргэний танхимд, сумдад тус тус хүргүүлэн мэдээллийн самбарт нааж байршуулсан. Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах, архидан согтуурахтай тэмцэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлж ажиллах талаар харилцан санал солилцох зорилгоор тус газраас Баянхонгор аймагт үйл ажиллагаа явуулж буй хуулийн байгууллагуудын дунд “Хуулиа мөрдье” сэдэвт зөвлөгөөнийг 2018 оны 02 дугаар сарын 08-ны өдөр зохион явуулж зөвлөгөөнөөс гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх чиглэлээр 15 заалт бүхий төлөвлөгөө гаргаж хэрэгжилтийг хангуулах чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллаж байна.

Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, тамхины хяналтын тухай хуулийн хүрээнд хийсэн ажлын хүснэгтэн мэдээг сар бүрийн 5-ны өдрийн дотор Нийтийн хэв журам хамгаалах газарт хүргүүлсэн.

Орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл ашиглан нийт 24 удаа иргэд олон нийтэд цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа болон гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдээ мэдээллийг нэвтрүүлсэн ба байгууллагын Facebook хуудас, цахим хаяг ашиглан иргэдэд урьдчилан сэргийлэх чиглэлээр бэлтгэсэн санамж, сэрэмжлүүлэг, шторк, богино хэмжээний кино болон байгууллагын үйл ажиллагааг сурталчилж ажиллаа.

Аймгийн Засаг даргын 2017 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн А/149 дугаартай “Нийтийн эргүүлийн хуваарь батлах” тухай захирамжийг хэрэгжүүлэн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх хэсэгт заасны дагуу Баянхонгор суманд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллагуудыг долоо хоног бүрийн баасан гарагт эргүүлд гарах хуваарийн дагуу одоогийн байдлаар “Нийтийн эргүүл”-д 2 аж ахуйн нэгж, байгууллагын 30 алба хаагч гарган ажиллуулж, үүрэг гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан.

Цагдаагийн газраас аж ахуй нэгжүүдэд нийт 22 мэдэгдэлд дугаар олгогдож 170 аж ахуй нэгж, байгууллага, албан тушаалтанд “Албан мэдэгдэл” хүргүүлэн хариуг авч, биелэлт үр дүнг тооцон ажиллаж байна.

Тус газар нь 2018 оны эхний 9 сарын байдлаар Улсын хэмжээний 16, цагдаагийн газрын хэмжээнд 38 нэгдсэн арга хэмжээ, 28 хэсэгчилсэн арга хэмжээ зохион байгуулж, 91 удаагийн нэгдсэн үзлэг шалгалтад гарч ажилласан ба 260 удаа сургалт, мэдээлэл, сурталчилгааны ажил зохион байгуулж, 81 удаа уулзалт ярилцлага, 22 удаагийн өдөрлөг, 1 удаа уралдаан тэмцээн зохион байгуулж ажилласан ба нийт 364 удаагийн арга хэмжээ зохион байгуулж, 17580 иргэнийг хамруулж ажилласан байна. Дээрх арга хэмжээнд 2240 төрийн болон төрийн бус байгууллагын ажилтан, 1044 хувиараа хөдөлмөр эрхлэгч, 725 малчин, 538 оюутан, 8135 сурагч, 3428 ажилгүй иргэд хамрагдсан. Үүнээс 377 аж ахуй нэгж байгууллагаас давхардсан тоогоор 121 төрийн байгууллага, 152 аж ахуй нэгж, 50 их дээд сургууль, коллеж, 59 ерөнхий боловсролын сургууль, 24 цэцэрлэг хамрагдсан байна.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр иргэн, аж, ахуй нэгж байгууллагад 92 албан мэдэгдэл хүргүүлж 89 албан мэдэгдлийн хариуг авч, биелэлт үр дүнг тооцож ажилласан байна.

Зах, худалдааны төвийн удирдлагуудтай хамтран ажиллах гэрээ байгуулан, хулгайн эд зүйл худалдан борлуулсан /ченж/ иргэдийн үйл ажиллагааг таслан зогсоож, түрээсийн гэрээг цуцлуулах арга хэмжээ авах талаар гэрээг байгуулж үр дүнг тооцон ажиллаж байна.

“Сар шинэ 2018” нэгдсэн арга хэмжээний хүрээнд захиргааны хяналт анд байгаа 72 иргэнтэй уулзалт хийлгэж, баяр амралтын өдрүүдэд согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэхгүй байх, дахин гэмт хэрэг зөрчилд холбогдохгүй байх талаар баталгаа гаргуулан, хувийн хэрэг материалд нь хавсаргаж, Зам тээврийн осол, хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 365 ширхэг санамж, сэрэмжлүүлэг, зурагт хуудсыг иргэн, аж ахуй нэгжүүдэд тарааж, 26 аж ахуй нэгжид урьдчилан сэргийлэх чиглэлээр албан мэдэгдэл өгч баяр, амралтын өдрүүдэд үүрэг гүйцэтгэх хуваарийг авч ажилласан.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулах телевизүүдэд тасаг албадаас мэдээлэл өгөх хуваарийг гаргаж, хуваарийн дагуу тасаг албадаас долоо хоног бүрийн мягмар гарагт мэдээлэл хийж байна.

Аймгийн хэмжээнд сүүлийн таван жилийн криминологи судалгааны баг ажиллах гэрээг байгуулан ажлыг эхлүүлэн, мэргэжлийн багийн судалгааны ажил эхлэн явагдаж байна.

Тус газрын алба хаагчдаас энэ оны эхний 09 сарын байдлаар ажилд орох, суралцахыг хүссэн 10, ажилд дахин орохыг хүссэн 20, ажил өөрчлөх, шилжихийг хүссэн 58, захиргааны чөлөө хүссэн 70, тэтгэвэр, тэтгэмж, орон сууц хүссэн 20, бусад 180 нийт 361 өргөдлийг хүлээн авч шуурхай шийдвэрлэх чиглэлээр удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авч ажилласны үр дүнд өргөдөл, гомдлын үлдэгдэлгүй байна.

Цагдаагийн ерөнхий газрын тэргүүн дэд даргаас 2018 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн 02/424 дугаартай ажлын чиглэл, “UNFRIEND ХӨДӨЛГӨӨН” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах салбар төлөвлөгөөг алба хаагчдад танилцуулж, нотломж үйлдэн алба хаагчдаар гарын үсэг зуруулан, 2018 оны 09 дүгээр сарын 05-ны өдрөөс 27-ны өдөр хүртэл хугацаанд зохион байгуулагдах арга хэмжээг иргэд олон нийтэд сурталчилж, өөрсдийн фэйсбүүк хаягийн ковор зургийг UNFRIEND хүрээгээр сольж, арга хэмжээг дэмжин ажиллахыг уриалсан. Байгууллагын жагсаалын талбайд “UNFRIEND” гэсэн бичгийг хэвлүүлж, байрлуулан, Цагдаагийн ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх хэлтсээс ирүүлсэн 38 ширхэг постер, 12 ширхэг видео шторк, Хууль зүй, дотоод хэргийн яам, Цагдаагийн ерөнхий газар, Монгол улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлөөс хамтран цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр гаргасан 3 төрлийн тараах материалыг ерөнхий боловсролын 6 сургууль, 2 дээд сургууль, 1 политехникийн коллежийн 1300 оюутан сурагчдад, 500 гаруй иргэдэд олшруулан тараасан.

Гэмт хэргээс Урьдчилан сэргийлэх тухай хуулийн 12 дугаар зүйлд заасны дагуу аймгийн Засаг даргын 2018 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн А/149 дугаартай “Нийтийн эргүүлийн хуваарь батлах тухай” захирамж гаргуулан нийт 44

байгууллагыг хуваарьт оруулан долоо хоног бүрийн “баасан” гарагт нэг байгууллагаас ажилтан, алба хаагчдыг зориулалтын хантаазтайгаар, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр эргүүлд гарган ажиллуулсан. 2018 оны 09 дүгээр сарын байдлаар 14 байгууллагын 140 ажилтан алба хаагч ажилласан байна.

2018 оны 01 дүгээр сарын байдлаар нийт 78 хорихоос өөр төрлийн ялтай иргэний материал байснаас 09 дүгээр сарын байдлаар 56 ялтны хяналтын хугацаа дууссан үлдэгдэл 22 материал хяналтад байна. 2018 он гарсаар сар бүр хяналтын материалыг прокурорт хянуулсан ба захиргааны хяналт тогтоох эрх бүхий албан тушаалтнуудад зааварчилга өгч, хяналтыг үргэлжлүүлэн тогтоон ажиллаж байна.

Хоёр: Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр

Цагдаагийн газар нь 2018 оны эхний 9 сарын байдлаар нийт 2743 гомдол, мэдээлэл хүлээн авсан нь урьд оны мөн үетэй харьцуулахад 83 нэгжээр буюу 3 хувиар өссөн байна. Үүнээс 696 буюу 25.3 хувийг гэмт хэргийн шинжтэй 2047 буюу 74.6 хувийг зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл байна.

Баянхонгор аймгийн хэмжээнд 427 гэмт хэрэг бүртгэгдэн шалгагдсан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 61 нэгжээр буюу 14.2 хувиар өсч, бүртгэгдсэн гэмт хэргийн 103 буюу 24.1 хувь нь хүнд, 324 буюу 75.8 хувь нь хөнгөн ангиллын гэмт хэрэг байна.

Энэ хугацаанд хэрэг бүртгэл тийн 396 эрүүгийн хэрэг бүртгэгдсэнээс 189 хэргийн холбогдогчид ял сонсгон, яллагдагчаар татаж гэмт хэргийн илрүүлэлт 47.7 хувьтай, 252 хүн холбогдон шалгагдсан нь 71 нэгжээр буюу 21.9 хувиар буурсан байна.

Гэмт хэргийн улмаас 400 хүн хохирч, 135 хүн гэмтэж, 10 хүн нас барж, 536.7 сая төгрөгийн хохирол учирснаас 167.6 сая төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж, хохирол нөхөн төлүүлэх 31.2 хувьтай, 59.6 сая төгрөгийн эд хөрөнгө битүүмжилсэн.

Аймгийн хэмжээнд энэ хугацаанд 2047 зөрчил бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 194 буюу 9.4 хувиар өссөн, нийт 1649 зөрчил шийдвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 485 нэгжээр буюу 29.4 хувиар өссөн.

Ердийн журмаар 11992 зөрчлийг 282024.9 мянган төгрөгөөр, 1338 зөрчлийг хялбаршуулан шалгах журмаар шийдвэрлэж 236635.0 мянган төгрөгийн торгууль ногдуулж, 278 хүнд баривчлах шийтгэл ногдуулсан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 56 нэгжээр буюу 25.2 хувиар өсч, 377 зөрчлийг торгож эрх хассан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 70 нэгжээр буюу 22.8 хувиар өсч, зөрчлийн улмаас нийт 87 иргэн хохирсон байна.

Эрүүгийн цагдаагийн албаны чиглэлээр: 2018 онд зохион байгуулах сургалтын төлөвлөгөөг гарган цагдаагийн газрын нэгдсэн төлөвлөгөөнд тусгуулан батлуулж, хэсгийн төлөөлөгч нарын сургалтыг 2018 оны 02 дугаарын 05-ны өдрөөс 2018 оны 02 дугаар сарын 06-ны өдрүүдэд, хамруулсан 2018 оны 09 дүгээр сарын 13-ны өдрөөс 2018 оны 09 дүгээр сарын 15-ны өдрүүдэд тус бүр зохион байгуулж, дотоод бичиг баримт, объектын судалгаа, бүртгэл, эрүү, хэв журам, замын

хөдөлгөөний болон ГА-ын нөхцөл байдлыг судлах, гэмт хэрэг, зөрчил илрүүлэхэд хэрхэн ашиглах талаар нийт 23 цагийн сургалтыг зохион байгуулан ажилласнаас хуулийн байгууллагуудын хамтарсан зөвлөгөөнд нийт хэсгийн төлөөлөгч нарыг хамруулсан. Мөн 2018 оны 09 дүгээр сарын 13-ны өдрөөс 09 дүгээр сарын 14-ны өдрүүдэд цагдаагийн газрын даргын тушаалаар “шилдэг хэсгийн төлөөлөгч” уралдааныг зохион байгуулж хэсгийн төлөөлөгч нарыг хамруулсан.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам код 307.5.2-ын дагуу цагдаагийн газрын алба хаагчдаас нийт гэмт хэрэг, зөрчлийн талаар 228 илтгэх хуудас авч шалгасан.

Энэ оны эхний 9 сарын байдлаар тус тасгийн алба хаагчид гэмт хэргийн шинжтэй 559 дуудлага, мэдээлэл хүлээн авч 377 гомдол, мэдээлэлд хэрэг бүртгэл тийн хэрэг нээн, 158 дуудлага мэдээллийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах саналтай прокурорт хүргүүлж, 341 сая төгрөгийн хохиролтой 105 хэргийг илрүүлэн холбогдох албанд тушаалтанд шилжүүлж, 48 хэргийн хаах саналтай прокурорт хүргүүлсэн

Эрэн сурвалжлах ажлын чиглэлээр 2018 оны 3 дугаар улирлыг байдлаар байдлаар Эрэн сурвалжлах ASAP санд оргодол 6, гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээд 33, оршин суугаа газраасаа алга болсон хүн 8, шүүхээс даалгасан хүн 15, мал, амьтан 2, эд зүйл 13, аман зургаар 1, нийт 78 эрэн сурвалжлалт зарласнаас оргодол 4, гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээд 11, оршин суугаа газраасаа алга болсон хүн 7, шүүхээс даалгасан хүн 7, нийт 29 хүн, мал, эд зүйлийг олж тогтоон эрэн сурвалжлалтыг зогсоосон байна. Энэ нь урьд оны мөн үетэй харьцуулахад 25 хувиар өссөн байна

Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, бод малыг оторлон маллах арга туршлагыг нэвтрүүлэх, сурталчлах зорилгоор Монголын Үндэсний телевизийн “Эргэх дөрвөн цаг” нэвтрүүлэгтэй хамтран Галуут сумын 4 дугаар багийн нутаг “Гурван цармын нуруу” гэх газар 6 сумын 10000 гаруй адууг оторлон маллаж байгаа залуучууд, адууг оторлон маллахын ач холбогдлын талаар нэвтрүүлэг хийсэн. Аймгийн хэмжээнд малын хулгайн гэмт хэрэг үйлддэг болон үйлдэж болзошгүй 92 хүний дэлгэрэнгүй судалгааг гарган үйл хөдөлгөөнд нь хяналт тавьж, “Малчдын бүлэг”-ийн үйл ажиллагааг идэвхжүүлэн, удирдлага зохион байгуулалтаар ханган ажилласан.

Мал хулгайлах болон Хүрээн буй орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсооход бүс нутгийн хамтын ажиллагаа” хангайн бүсийн уулзалт зөвлөгөөн 2018 оны 05 дугаар сарын 03-ны өдөр Архангай аймгийн Цэцэрлэг хотод зохион байгуулагдаж, зөвлөгөөнд цагдаагийн газрын дарга, мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх ахлах мөрдөгч, эдийн засгийн мөрдөгч нар оролцож, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр хийсэн ажлын талаар мэдээлэл хийж, цаашид мал хулгайлах болон хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсооход бүс нутгийн хамтын ажиллагааг сайжруулан тодорхой ажлуудыг зохион байгуулахаар шийдвэрлэсэн.

Үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлийг бууруулах, амар тайван амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд иргэд, төрийн байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор “Амар амгалан амьдралыг бий болгоход иргэд болон нутгийн өөрөө удирдах байгууллагын

оролцоог сайжруулах нь” сэдэвт хэлэлцүүлгийг сумдын ИТХ-ын дарга, удирдлага, иргэд нийт 360 орчим иргэдийн оролцуулан хэлэлцүүлэг зохион байгуулсан.

Шуурхай удирдлагын тасгаас: иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас Цагдаагийн газрын жижүүрийн шуурхай албанд ирсэн 2743 мэдээ мэдээллийг хүлээн авч мэдээлэлд оруулан удирдлагад танилцуулж ажилласнаас гэмт хэргийн шинжтэй 696 мэдээлэл, зөрчлийн шинжтэй 2047 мэдээллийг хүлээн авч, камерын хяналтаар 3 зөрчил илрүүлж, иргэдээс ирсэн хүсэлтийн дагуу 12 удаа камерын бичлэг шүүж ажилласан.

Жижүүрийн үүрэг гүйцэтгэх хугацаанд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн мэдээллийн дагуу олон нийтийн газар, орон гэртээ болон ахуйн хүрээнд бусдын амгалан тайван байдал алдагдуулсан гэх зөрчил гаргаж агсан тавьсан 669 хүнийг саатуулах баривчлах байранд хүргэн эрүүлжүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгч, шуурхай шийдвэрлүүлж ажилласан.

Иргэд аж ахуй нэгж, байгууллагаас ирүүлсэн зөрчлийн шинжтэй нийт 1410 гомдол мэдээлэл хүлээн авснаас жижүүрийн шуурхай албанд ирүүлсэн 1330, бичгээр ирүүлсэн 80 өргөдөл гомдлыг нэгдсэн програм хангамжид шивж оруулан, эрүүлжүүлэгдсэн 558 хүний 2.652.3 төгрөгийг төлүүлж, ердийн журмаар 14124 зөрчлийг 327852.6 мянган төгрөгөөр, 911 зөрчлийг хялбаршуулан шалгах журмаар шийдвэрлэж 239880.0 мянган төгрөгийн торгууль ногдуулсан, 406 зөрчлийг торгож эрх хассан, 313 хүнд баривчлах шийтгэл ногдуулсан шийдвэрлэлтүүд болон хохирсон 87 иргэний мэдээллүүдийг нэг бүрчлэн хянаж, мэдээллийн нэгдсэн сангийн тоо бүртгэлд явуулсан.

Мөрдөн байцаах тасгаас: энэ оны эхний 9 сарын байдлаар Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн гэмт хэргийн шинжтэй 255, урьд оны үлдэгдэл 7 гомдол, мэдээлэл нийт 262 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 184 буюу 70.2 хувьд нь хэрэг бүртгэл тийн хэрэг нээж, 20 буюу 7.6 хувьд нь эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татаж, 45 буюу 17.1 хувийг нь хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах санал гарган прокурорт шилжүүлж, 9 буюу 3.4 хувийг нь харъяаллын дагуу шилжүүлж, одоо 4 гомдол, мэдээллийн үлдэгдэлтэй байна.

Тайлангийн хугацаанд урьд оны үлдэгдэл хэрэг бүртгэлийн 66, 2018 оны 3 дугаар улирлын байдлаар нээсэн хэрэг бүртгэлтийн 184, хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах саналтайгаар шилжүүлсэн материалаас хэрэг бүртгэлтийн хэрэг нээж ирүүлсэн 7, бусад газраас харъяаллын дагуу шилжүүлж ирүүлсэн 65, прокуророос хэрэг бүртгэлтийн хэргээс тусгаарлан ирүүлсэн 1 хэрэг нийт 323 хэрэгт хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулж, 109 хэргийг эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татаж, хэрэг бүгэлтийн 114 хэргийг хааж, 37 хэргийг харъяаллын дагуу шилжүүлж шийдвэрлэн 63 хэргийн үлдэгдэлтэй байна.

Урьд оны мөрдөн байцаалтын үлдэгдэл 13, 2018 оны 3 дугаар улирлын байдлаар хэрэг бүртгэлтийн хэргээс эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татсан 109, шууд эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан 20, бусад газраас харъяаллын дагуу шилжүүлж ирүүлсэн 41, түдгэлзүүлснээс сэргээсэн 3 хэрэг нийт 186 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж, 200 холбогдогчтой 145 хэргийг шүүхэд шилжүүлэх, 1 холбогдогчтой 1 хэргийг хэрэгсэхгүй болгох, 4 холбогдогчтой 4 хэргийг харъяаллын дагуу шилжүүлэх саналтай тус тус прокурорын хяналтад шилжүүлж шийдвэрлэн, 32 хэргийг нэгтгэж одоо 4 хэргийн үлдэгдэлтэй байна.

2018 оны 03 дугаар улирлын байдлаар мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан 186 хэргээс 7 хэргийн мөрдөн байцаалтын хугацааг сунган шалгаж 96.3 хувийг хуулийн анхны хугацаанд шийдвэрлэсэн.

Тайлант хугацаанд аймгийн Прокурорын газраас 6 хэрэг, шүүхээс 4 хэрэг нэмэлт мөрдөн байцаалтын ажиллагаа хийлгэхээр буцаасныг шалгаж шийдвэрлэн 6 хэргийг шүүхэд шилжүүлэх саналтай, 1 хэргийг хаах саналтай, 1 хэргийг харьяаллын дагуу шилжүүлэх саналтайгаар прокурорын хяналтад шилжүүлж шийдвэрлэн одоо прокуророос буцсан 2 /хэрэг бүртгэлийн 1, мөрдөн байцаалтын 1 хэрэг/ хэргийн үлдэгдэлтэй.

Гэмт хэргийн улмаас 271.5 сая төгрөгийн хохирол иргэд аж ахуйн нэгж байгууллагад учирснаас мөрдөн байцаалтын шатанд 240.3 сая төгрөг буюу 88.5 хувийг нөхөн төлүүлж, шүүхээс эд хөрөнгө хураах, иргэний нэхэмжлэлийг хангах зорилгоор сэжигтэн, яллагдагчийн гэмт хэрэг үйлдэхдээ ашигласан болон хувьд ногдох 275.6 сая төгрөгийн эд хөрөнгийг битүүмжилсэн.

Шүүхэд шилжүүлэх саналтай прокурорт шилжүүлсэн 145 хэрэгт гэмт хэрэг гарсан шалтгаан нөхцөлийг тогтоож арилгуулах, гэмт хэрэг дахин гарахаас урьдчилан сэргийлэх зорилгоор мөрдөгчийн мэдэгдэл хүргүүлж 116 мэдэгдлийн хариуг авч ажилласан.

Хэрэг бүртгэх тасгаас энэ оны эхний 9 сарын байдлаар ЦЕГ-ын Тэргүүн дэд даргын 2018 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 2/48 дугаартай үүрэг, ажлын чиглэл, Хэрэг бүртгэх албаны даргын болон дэд дарга, хэлтсийн дарга нараас ирүүлсэн үүрэг, ажлын чиглэлийг тасгийн алба хаагчид танилцуулж, хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган ажил зохион байгуулж хугацаанд нь хариу хүргүүлэн ажилласан.

Шинэчлэн батлагдсан хуулиудыг судалж, хэрэгжүүлэхэд гарч буй хүндрэл бэрхшээл, хуулийг нэг мөр ойлгож хэрэгжүүлэх, шийдвэрлэх арга замын талаар Эрүүгийн хэргийн анхан шатны Шүүх, аймгийн Прокурорын газрын орлогч прокурор, зөрчил шалгах ажиллагаанд хяналт тавих прокурортой хамтарсан уулзалтыг 3 удаа зохион байгуулсан.

Хэрэг бүртгэх тасаг нь 2018 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн Эрүүгийн хуулийн 11 дүгээр бүлэгт заасан гэмт хэргийг харьяалуулан мөрдөн шалгах ажиллагаа явуулахаар шийдвэрлэсэн. Үүнтэй холбоотойгоор тус тасагт шалгагдаж байсан Зөрчлийн тухай хуулийн 5.2, 5.4, 8.6 дугаар зүйлүүдэд заасан 12 гомдол, мэдээлэл, 27 зөрчлийн хэргийг холбогдох албадад хүлээлгэн өгөхдөө мэдээллийн сан болон тасагт хөтлөгдөж байгаа бүртгэл судалгаагаар нэг бүрчлэн тулгаж, хэрэг, материалын хуудас бүрийг дугаарлан хавтаслаж, хэрэг материалыг Нийтийн хэв журам хамгаалах тасгийн даргад дэлгэрэнгүй хүснэгтээр хүлээлгэн өгч, 2018 оны 02 дугаар сарын 01-нээс тус газрын Эрүүгийн цагдаагийн тасгаас хэрэг бүртгэлтийн 10, Мөрдөн байцаах тасгаас гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 1, хэрэг бүртгэлийн 21, нийт хэрэг бүртгэлтийн 31 хэрэг, гомдол, мэдээлэл 1-ийг тус тус харьяаллын дагуу хүлээн авч мөрдөн шалгах ажиллагаа явуулсан.

Тайлангийн хугацаанд иргэд, байгууллага, хуулийн этгээдээс гэмт хэргийн шинжтэй 164 гомдол, мэдээлэл хүлээн авч, 136 гомдол, мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 25 гомдол, мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс

татгалзаж, 1 гомдол мэдээлэлд мөрдөн байцаалтын хэрэг нээж, одоо ажиллагаанд 1 гомдол мэдээллийн үлдэгдэлтэй байна.

Энэ хугацаанд тус тасаг нь 2018 оны 02 дугаар сарын 01-ны өдрөөс Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11 дүгээр бүлгийн харьяаллын хэрэг шалгахтай холбогдуулан Мөрдөн байцаах тасаг, эрүүгийн цагдаагийн тасаг болон бусад газраас нийт 40 хэргийг хүлээн авч, шинээр хэрэг бүртгэлтийн 136 хэрэг нээж, хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан 3 материал Прокурорын газраас ирүүлснийг хүлээн авч нийт 176 хэрэгт хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулсан.

Хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулсан 176 хэргээс 96 үйлдэлтэй, 98 холбогдогчтой, 96 хэргийг эрүүгийн хэрэг үүсгэн яллагдагчаар татаж, 30 үйлдэлтэй хэргийг хэрэг бүртгэлтийн хэргийг хаах саналтай прокурорт хүргүүлэн, 3 хэргийг харьяаллын дагуу шилжүүлж одоо ажиллагаанд 51 хэрэг бүртгэлтийн хэргийн үлдэгдэлтэй байна.

Нийт 98 хүнд холбогдох 96 мөрдөн байцаалтын хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулснаас 94 хүнд холбогдох 92 үйлдэлтэй 92 хэргийг шүүхэд шилжүүлэх саналтайгаар прокурорт шилжүүлсэн. Одоо ажиллагаанд 4 хүнд холбогдох, 4 үйлдэлтэй 4 мөрдөн байцаалтын хэрэг шалгагдаж байна.

Гэмт хэргийн улмаас иргэд, байгууллага, аж ахуйн нэгжид 71.8 сая төгрөгийн хохирол учирснаас мөрдөн шалгах ажиллагааны явцад 52.3 сая буюу нийт хохирлын 73 хувийг нөхөн төлүүлсэн.

Тасгийн алба хаагч нараар 7 хоногийн төлөвлөгөө, өдөр тутмын тэмдэглэл хөтлүүлж хийсэн ажлын тэмдэглэлтэй өдөр бүр, шалгаж буй гомдол, мэдээлэл, хэрэг бүртгэлтийн болон мөрдөн байцаалтын хэрэгтэй тухай бүр танилцан, мэргэжлийн удирдлагаар хангах үүднээс тасгийн дарга, ахлах мөрдөгчөөс 35 зааварчилгааг бичгээр өгч биелэлтийг тооцон ажилласан байна.

Замын цагдаагийн тасгаас энэ оны эхний 9 сарын байдлаар зам тээврийн осол, хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, шалтгаан нөхцөлийг арилгуулах зорилгоор албан байгууллага, албан тушаалтанд 24 удаа албан мэдэгдэл бичиж, тодорхой ажил арга хэмжээ зохион байгуулсан талаар 16 албан мэдэгдлийн хариуг авсан.

Аймгийн хэмжээнд 2017 онд гарсан зам тээврийн хэрэг, ослын 63 хувь нь мотоциклтой холбоотой гарсанд дүгнэлт хийн, мотоцикл эзэмшигч нарыг “А” ангиллын эрхийн үнэмлэхжүүлэх, замын хөдөлгөөний дүрмийн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор “Мотоцикл эзэмшигч нарын гарын авлага” нэртэй дүрмийн сургалтын номын эх загварыг бэлтгэн 500 ширхгийг хэвлүүлэн тараасан. Баянхонгор аймгийн төв рүү ордог улсын чанартай замын Шаргалжуут салдаг уулзварт байрлуулсан 5х3 метрийн хэмжээтэй самбарыг Аялал жуулчлалын газартай хамтран битүү төмөрлөж 2 төрлийн зураг самбарыг шинээр хэвлүүлэн байрлуулах ажлыг зохион байгуулсан. Замын цагдаагийн албаны чиглэлээр Зам тээврийн осол, хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, шалтгаан нөхцөлийг арилгуулах зорилгоор албан байгууллага, албан тушаалтанд 24 удаа албан мэдэгдэл бичиж, мэдэгдлийн мөрөөр зохион байгуулсан ажлын талаар 16 байгууллага, албан тушаалтан хариу ирүүлсэн.

Аймгийн Засаг даргын “Мотоциклийн хөдөлгөөн түр хязгаарлах тухай” А/767 тоот захирамжийн хүрээнд “Мотоциклын бүртгэл” сэдэвт арга хэмжээг 3 сарын хугацаатай зохион байгуулж, хамгаалах малгайгүй 658 жолоочийг хамгаалах

малгайлжуулан, “А” ангиллын тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэхгүй 650 хүнийг үнэмлэхжүүлэн 674 мотоциклыг бүртгэлжүүлэн, улсын дугаар олгох ажлыг Авто тээврийн төвийн Баянхонгор аймаг дахь салбар, жолооны курсүүдтэй хамтран зохион байгуулсан.

Замын цагдаагийн тасгийн алба хаагчид 2018 эхний 9 сарын байдлаар ЗамынХөдөлгөөнийаюулгүйбайдалашиглалтынжурмынэсрэггэмтхэрэг, осолзөрчлөөс урьдчилансэргийлэх чиглэлээр гудамж замд хийсэн хяналт, шалгалтаар замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, тогтоомж зөрчсөн 11209зөрчил илрүүлснээс согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон 644, тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэхгүй тээврийн хэрэгсэл жолоодсон 255, хүн ба ачаа тээвэрлэх журам зөрчсөн 2711, хамгаалах бүс хэрэглээгүй 4874, үзлэг оношлогоонд хамрагдаагүй болон бүрэн бус 602 , бусад зөрчил 3736-ийг тустусилрүүлж, бэлэн бусаар 10606 жолоочийг 247.225.350 төгрөгөөр торгож, цаашид замын хөдөлгөөнд оролцох боломжгүй зөрчилтэй 808 тээврийн хэрэгслийг түр саатуулж ажиллалаа.

Хөдөлгөөний аюулгүй байдлын журам зөрчсөн 899 захиргааны зөрчил шалгаснаас Зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар зүйлийн 3.1 дахь хэсэгт зааснаар 393 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасч, 157,200.000 төгрөгөөр торгож, мөн хуулийн 14.7 дугаар зүйлийн 14.7.5 дахь хэсэгт зааснаар 251 иргэнд Зөрчлийн хэрэг нээж, аймгийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр шийдүүлж, Зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар зүйлийн 14.7.1 дэх хэсэгт зааснаар 255 иргэнд 51,000,000 төгрөгний торгууль ногдуулж, нийт 11190 хүнийг 434.625.350 төгрөгөөр торгож ажиллалаа.

Мөн нийтийн тээврийн хот хоорондын үйлчилгээ эрхэлдэг 2 аж ахуй нэгжид өгсөн албан мэдэгдлийн дагуу том оврын автобуснуудыг камержуулсан байдалд шалгалт хийсэн. “Хот хоорондын ачаа тээвэрлэлт” нэгдсэн арга хэмжээний хүрээнд ТВ-10, Хонгор телевизүүдэд сэрэмжлүүлэг, нэвтрүүлэг хийж, 2 төрлийн 50 ширхэг санамжийг хэвлүүлэн “Баянхонгор-тээвэрчин” хоршооны жолооч нарт тараах ажлыг зохион байгуулсан.

Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг Зэвсэгт хүчний 339 дүгээр анги, Онцгой байдлын газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын алба хаагчдыг “А” ангиллын тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх сургалтанд хамруулан, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Замын хөдөлгөөний дүрмийн сургалтыг зохион байгуулж, нийт 560 иргэнийг “А” ангиллын эрхийн үнэмлэхжүүлэх ажлыг зохион байгуулсан.

“Миний аав хамгийн сайн жолооч гар зургийн уралдааны удирдамжийг гарган 06 дугаар сарын 01-ны өдөр зохион байгуулахаар Боловсрол, соёл, урлагийн газар, Ерөнхий боловсролын сургуулиудад хүргүүлсэн. Аймгийн хэмжээний ерөнхий боловсролын 25 сургууль, 34 цэцэрлэгт “Аюулгүй замын хөдөлгөөнд оролцох нь “ сэдэвт сургалтыг Замын цагдаагийн тасгийн дарга, ахлах зохицуулагч, урьдчилан сэргийлэх ажил хариуцсан ахлах мэргэжилтэн, гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил хариуцсан ахлах мэргэжилтэн, сумдын хэсгийн төлөөлөгч нар зохион байгуулсан.

Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр “Автомашингүй өдөр” арга хэмжээг зохион байгуулах тухай Баянхонгор сумын Засаг даргын 2018 оны 05

дугаар сарын 24-ны өдрийн 132 тоот захирамжийг гаргуулан төв гудамж замыг хаах схем зураглал үйлдэн олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулсан.

ЗЦА-ны дэд даргын баталсан удирдамжийн дагуу “Оюутан тээвэр-2” арга хэмжээг АТҮТ-ийн Баянхонгор салбартай хамтран зохион байгуулж, хяналт шалгалтыг өдөр бүр 14-02 цагийн хооронд нэмэлтээр 24 цагаар постоор хийж, нийтийн тээвэртэй холбоотой 16 зөрчлийн холбогдох албан тушаалтанд шилжүүлэн арга хэмжээ тооцуулан ажиллаж байна.

“Оюутан тээвэр 2” нэгдсэн арга хэмжээг аймгийн АТҮТ-ийн салбарын байцаагч нар болон татвар, даатгалын байцаагч нартай хамтарсан эргүүл шалгалтыг өдөр бүр 10-16 цагаар ажиллуулан, дамжин өнгөрч байгаа болон тус аймгаас хот хоорондын зорчигч тээврийн том оврын автобуснуудад үзлэг шалгалт хийж ажилласан.

Нийтийн хэв журам хамгаалах тасаг нь энэ оны эхний жилийн байдлаар Баянхонгор сумын 9 багт гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох зорилгоор хэв журмын оройн эргүүлийн 3 чиглэлд 6 цагдаа, 1 офицер, өдрийн эргүүл 1 цагдаа, шөнийн эргүүлд 1 цагдаа, хөдөлгөөнт эргүүлийн 1 автомашинтай 2 алба хаагчдыг өдөр бүр, нөхцөл байдалтай уялдуулан чиглэл, маршрутыг тогтоон томилж, үр дүнг тооцож ажиллуулсан. Явган эргүүлд давхардсан тоогоор нийт 546 алба хаагч, 4380 цагийн үүрэг гүйцэтгэж, 1274 аж ахуйн нэгж, байгууллага, 1248 иргэн, 510 тээврийн хэрэгсэлд үзлэг шалгалт хийж ажилласан.

Хөдөлгөөнт эргүүлд 3 автомашинаар өдөр бүр ээлжлэн давхардсан тоогоор 240 алба хаагч, 1080 цагийн эргүүлийн үүрэг гүйцэтгэж, 8522 км зам туулж, 816 дуудлага, мэдээлэл хүлээн авч, зөрчил гаргасан 842 иргэнийг албадан эрүүлжүүлэх байрны эмч, цагдаа нарын хяналт анд хүлээлгэн өгч, биеэ авч явах удирдан жолоодох чадваргүй 68 иргэнийг ар гэрт нь хүлээлгэн өгч ажилласан.

Аймгийн Онцгой комиссын 2018 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн хурлын шийдвэр, аймгийн Засаг даргын 2018 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн А/70 дугаартай “Мал амьтны гоц халдварт өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх хяналтын пост ажиллуулах тухай” захирамжийг гаргуулж, үүрэг гүйцэтгэх мэргэжлийн анги, байгууллагын уялдаа холбоо, ажилтан алба хаагчдын ажиллах нөхцөл орчин, хуваарь томил гоо, удирдлага зохион байгуулалт, унаа, шатахуун, томилолтын зардал зэрэг асуудлын тооцоо, судалгааг гарган хүргүүлж, цогцоор нь шийдвэрлүүлсэн.

Мэргэжлийн хяналтын газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Цагдаагийн газраас хамтран 2018 оны 01 дүгээр сарын 15-ны өдрөөс 2018 оны 02 дугаар сарын 15-ны өдөр хүртэл 30 хоногийн хугацаатай Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.1, 7.2.2, 7.3.1, 7.4 дэх заалтын хэрэгжилтийг хангах, хүүхэд залуучууд, олон нийтэд нөлөөллийн ажлыг өрнүүлэн “Хуулиа мөрдье-21” арга хэмжээний хүрээнд 24 заалт бүхий төлөвлөгөөг боловсруулж, архи, согтууруулах ундаа худалдан борлуулдаг, түүгээр үйлчилдэг нийт 115 аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагааг шалгаж, хугацаатай албан мэдэгдэл өгч, хариуг хугацаанд нь авсан.

Мөн тус газрын “Тусгай хэсэг”-ийн алба хаагчдын албаны бэлтгэл, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор ЦЕГ-ын Тусгай ажиллагааны газраас

мэргэшсэн алба хаагчдыг урьж ирүүлэн батлагдсан хөтөлбөрийн дагуу 5-хоногийн сургалтыг амжилттай зохион явуулсан.

Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн Баянхонгор аймаг дахь салбар, нэг цэгийн үйлчилгээний төв буюу Жендерт суурилсан хүчирхийлэлд өртөгчдөд үйлчилгээ үзүүлэх хамгаалах байранд гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн насанд хүрсэн 19 эмэгтэй, насанд хүрээгүй 7 эрэгтэй, 10 эмэгтэй хүүхэд нийт 36 хүнийг холбон зуучилж, байрлуулан аюулгүй байдлыг нь хангаж ажилласан.

Эрүүлжүүлэх, Саатуулах, баривчлах байранд хөтөлөгдвөл зохих бүртгэл судалгааг цаг тухай бүрд баяж илт хийж бүртгэж ажилласан.

Согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ зөрчил гаргасны улмаас Эрүүлжүүлэх байранд хүргэгдэн ирсэн 842 хүнийг журмын дагуу хүлээн авч, хяналт тавьж ажилласан.

Зөрчлийн улмаас 24 цагаар албадан саатуулагдсан 23 хүнийг зохих журмын дагуу тогтоолын хамт хүлээн авч, тогтмол хяналт тавьж ажилласан.

2018 оны гуравдугаар улирлын байдлаар Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж 7-30 хоногийн хугацаатай шүүхийн шийтгэврээр баривчлагдсан 110 иргэнд тэдний зан үйлд нөлөөлөх болон хууль эрх зүйн мэдлэг олгох албадан сургалтыг “Хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалтын журам”-д заасны дагуу төлөвлөгөөг сараар гарган Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн 1 цэгийн үйлчилгээний төв, Энх-уран итгэл хууль зүйн товчоо, Хүний эрхийн үндэсний комиссын Баянхонгор аймаг дахь салбар, Эрүүл мэндийн газартай хамтран хуваарийн дагуу зохион байгуулсан. Үүнээс гадна гэр бүл судлаач, доктор Г.Наранбаатарын лекц болон Монголын хүмүүнлэгийн хорооноос зохион байгуулсан аавуудын сургалтад хамруулсан.

Хүчирхийлэл үйлдэгч иргэдийн бүртгэл судалгаанд баяж илт хийж, хугацаа дуус ч суллагдах үед нь баталгаа авч ажилласан. Мөн баг хариуцсан хэсгийн байцаагч нар хариуцсан баг хороондоо гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч иргэдэд хяналтын хувийн хэрэг нээж, тогтмол баяж илт хийж, хяналт тавьж ажилласан.

2018 оны гуравдугаар улирлын байдлаар Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж 7-30 хоногийн хугацаатай шүүхийн шийтгэврээр баривчлагдсан 110 иргэнд тэдний зан үйлд нөлөөлөх болон хууль эрх зүйн мэдлэг олгох албадан сургалтыг “Хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалтын журам”-д заасны дагуу төлөвлөгөөг сараар гарган Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн 1 цэгийн үйлчилгээний төв, Энх-уран итгэл хууль зүйн товчоо, Хүний эрхийн үндэсний комиссын Баянхонгор аймаг дахь салбар, Эрүүл мэндийн газартай хамтран хуваарийн дагуу зохион байгуулсан. Үүнээс гадна гэр бүл судлаач, доктор Г.Наранбаатарын лекц болон Монголын хүмүүнлэгийн хорооноос зохион байгуулсан аавуудын сургалтад хамруулсан. хүчирхийлэл үйлдэгч иргэдийн бүртгэл судалгаанд баяж илт хийж, хугацаа дуус ч суллагдах үед нь баталгаа авч ажилласан. Мөн баг хариуцсан хэсгийн байцаагч нар хариуцсан баг хороондоо гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч иргэдэд хяналтын хувийн хэрэг нээж, тогтмол баяж илт хийж, хяналт тавьж ажилласан.

Эрүүлжүүлэх, Саатуулах, баривчлах байранд хүргэгдэн ирээд эмнэлгийн тусламж үйлчилгээ авах шаардлагатай болон архины хордлогын улмаас таталт өгсөн, артерийн даралт ихэссэн, зүрхний хэм алдагдсан, зүрх судасны өвчтэй, гар хөлийн шархтай гэх мэт нийт 169 хүнд эмнэлгийн анхны тусламж үзүүлсэн.

Баривчлагдсан хүмүүжигч нараас баривчлагдах хугацааны төлбөрийн тооцоог хийж барагдуулан төрийн сангийн 100030012001 тоот дансанд 6.696.900 төгрөг, эрүүлжүүлэгдсэн 515 хүний төлбөр болох 2.137.250 төгрөгийг тус тус байршуулсан. Гуравдугаар улирлын байдлаар эрүүлжүүлэгдсэн болон баривчлагдах хугацааны төлбөрийн тооцоо хийгээгүй 3 хүний төлбөр болох нийт 353.450 төгрөгийг төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргасан.

Шүүхийн шинжилгээний албаны Жив ой сканет эрүүлжүүлэгдсэн болон баривчлагдсан иргэдийн гарын хээг авахуулж санд бүртгүүлэн ажиллаж байна.

Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны Олон нийтийн аюулгүй байдлыг хангах газраас ирүүлсэн үүрэг, ажлын чиглэлийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж, аймгийн Шүүхийн тамгын газартай хамтран Хууль зүй, дотоод хэргийн сайд, Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын 2016 оны А/40:115 дугаартай хамтарсан тушаалаар батлагдсан “Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах” журмын хэрэгжилтийг ханган ажилласан.

Шүүхийн байранд харуулын 4 цагдааг батлагдсан хуваарийн дагуу 24 цагаар томилон ажиллуулж, шүүх хуралдааны үед дэг сахиулах цагдааг тухай бүр хурлын тов, хэргийн нөхцөл байдал, шүүгдэгчийн тоог үндэслэн хүн, хүчийг томилон ажиллуулсан.

2018 оны гуравдугаар улирлын байдлаар шүүхийн байранд эрүүгийн 210, иргэний 290, захиргааны 51, зөрчлийн 165, давж заалдах шатны 10 шүүх хурал болж ямар нэгэн зөрчилгүй журмын дагуу явагдсан. Шүүхийн байранд үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагч нараас шүүхийн байранд нэвтэрсэн 2382 хүний биед болон бичиг баримтад үзлэг шалгалт хийж нэвтрүүлсэн.

Мөн шүүхээс ирүүлсэн албадан ирүүлэх, эрэн сурвалжлах 16 захирамж шийдвэр хүлээн авч 10 захирамжид 12 хүнийг шүүхэд албадан ирүүлэх, хаяг тогтоох ажлыг хийж, одоо 21 захирамжид 24 хүнийг эрэн сурвалжлах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Гурав: Сахилга хариуцлага, сургалт сурталчилгаа, соён гэгээрүүлэх болон авилгаас урьдчилан сэргийлэх ажлын талаар

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2018 оны 02 дугаар сарын 14-ны өдөр өгсөн үрэг, ажлын чиглэл, тэргүүн дэд дарга, дэд дарга нараас алба хаагчдын сахилга, ажлын хариуцлагыг сайжруулах чиглэлээр ирүүлсэн 2018 оны 4/1237, 4/1708, 5/49, 5/60, 5/78 тоот албан бичгээр ирүүлсэн ажлын чиглэл, үүргийг хэрэгжүүлэх зорилгоор тус бүр 5-16 заалт арга хэмжээ бүхий ажлын төлөвлөгөөнүүдийг тус тус гарган, биелэлт, үр дүнг тооцон ажилласан.

Цагдаагийн газрын даргын 2018 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн А/16 дугаар тушаалаар “Ёс зүйн зөвлөл”-ийг шинэчлэн байгуулж, алба хаагчдын сахилга, хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр сахилгын зөвлөгөөнийг улирал тутам шинэлэг байдлаар хэлэлцүүлэг, кейс боловсруулан чөлөөт байдлаар зохион байгуулж, зөвлөгөөнөөс гарсан шийдвэрийг дараагийн улиралд хэрэгжүүлэн, тухайн улирлыг хариуцан авсан алба хаагчдаас биелэлтийг хангуулах чиглэлээр төлөвлөгөө гарган хэрэгжилтийг тооцон ажиллаж хэвшсэн.

Алба хаагчдаас харилцааны зөрчил гаргуулахгүй байх, гарч байгаа зөрчил, дутагдлын шалтгаан нөхцөлд судалгаа, дүн шинжилгээ хийж, урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээ зохион байгуулж, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг батлуулж, сургагч багшаар ажиллаж байгаа алба хаагчид болон сүүлийн 5 жилд сахилга, ёс зүйн зөрчил гаргаж байгаагүй алба хаагчдын туршлагаас судлах зорилгоор өглөө бүр 2 алба хаагчийн ажил, амьдралын туршлагаас яриулж, бусдад сургамж болох цагдаагийн албаны бахархан дуурайх зүйлийг алба хаагчдад танилцуулж ажилласан. Цагдаагийн алба хаагч бүрийг бие биендээ харилцааны ёс зүйн шаардлага тавьдаг, 8 алба хаагч тутмын 1-ийг харилцааны ёс зүй хариуцсан ахлахаар томилж, илэрсэн зөрчил дутагдлыг илрүүлж шийдвэрлүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч ажилласан. Алба хаагчдын сахилга, хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр ЦЕГ-ын удирдлагаас ирүүлсэн үүрэг, ажлын чиглэл бүрийг алба хаагчдад танилцуулан нотломж үйлдэн, ажлын чиглэл, үүргийг хэрэгжүүлэх, зөрчихгүй байх талаар 8 заалт бүхий баталгааг 93 алба хаагчаас бичгээр гаргуулан авсан. “Цагдаагийн алба хаагчийн харилцааны соёлыг дээшлүүлэх дэд хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх чиглэлээр 5 багц 18 заалт бүхий төлөвлөгөө гарган биелэлтийг тооцон гаргаж, 2018 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 33-2/1628 дугаартай албан бичгээр Аюулгүй байдлын хэлтэст хүргүүлсэн.

Цагдаагийн газрын даргын 2018 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн А/94 дүгээр тушаалаар “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын соёлыг төлөвшүүлэх хөтөлбөр, төлөвлөгөө хэрэгжүүлэх, “Байгууллагын соёлыг дээшлүүлье” аяныг зохион байгуулах ажлын хэсгийг байгуулж, ажлын хэсгээс Цагдаагийн газрын хэмжээнд хэрэгжүүлэх асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж, удирдамж, өгсөн үүргийг алба хаагчдад танилцуулж, хөтөлбөрийг алба хаагч, иргэд, олон нийтэд сурталчлах хэрэгжилтийг хангах ажлын салбар төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хөтөлбөр төлөвлөгөөг хэрэгжүүлэх, аяныг шинэлэг байдлаар, чанар, үр дүнтэй зохион байгуулж “Байгууллагын соёлыг дээшлүүлье” аяны нээлтийн арга хэмжээг 2018 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 11:40 цагт байгууллагын гаднах жагсаалын талбайд зохион байгуулж, иргэд, олон нийт болон хууль, хяналтын байгууллагын удирдлагууд, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилчид оролцуулж, алба хаагчдын ажиллах нөхцөл, боломжийг сайжруулах, байгууллагын соёлыг дээшлүүлэх, “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын соёлыг төлөвшүүлэх хөтөлбөр”-ийг иргэд, олон нийтэд сурталчлан таниулах, хэрэгжилтийг хангаж, удирдах ажилтны манлайлал, алба хаагчдын сахилга хариуцлага, харилцаа, хандлага, сэтгэл ханамжийг дээшлүүлж, иргэдийн цагдаад итгэх итгэлийг нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө танилцуулан, аяны хүрээнд зохион байгуулагдах урлаг, спорт, соён гэгээрүүлэх ажил, арга хэмжээнд идэвхтэй оролцохыг уриалан ажиллаж байна.

Алба хаагчдын сахилга, ёс зүйг дээшлүүлэх чиглэлээр 2018 оны эхний 9 сарын байдлаар “Ёс зүйн зөвлөл”-ийн гишүүд 6 удаа хуралдаж, цаашид хийж хэрэгжүүлэх 11 заалт бүхий ажлын төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтэд нь хяналт тавин ажилласан. Алба хаагчдын гаргасан зөрчил, дутагдлын талаар байгууллагын сахилга, хариуцлагын зөвлөгөөнөөр тухайн алба хаагчаар гаргасан зөрчлийнх нь шалтгаан, нөхцөлийн талаар бусад алба хаагчдад яриулж, дээрх зөрчлөөс урьдчилан сэргийлэх, дахин алдаа дутагдал гаргахгүй байхад анхаарах асуудлын талаар байгууллагын 2018 оны 01 дүгээр улирлын сахилгын

зөвлөгөөнийг энэ оны 03 дугаар сарын 22-ны өдөр ярилцлага, хэлэлцүүлэг хэлбэрээр зохион байгуулж, ажлын тайлан, мэдээг ЦЕГ-ын Аюулгүй байдлын хэлтэст хүргүүлсэн.

ЦЕГ-ын “Авлигаас урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн 2018 онд хийх ажлын төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг хангах чиглэлээр 2 багц 13 заалт бүхий ажил, арга хэмжээний салбар төлөвлөгөө боловсруулан батлуулж, биелэлтийг хангуулах чиглэлээр удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажилласан. Алба хаагчдын 2018 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн бүрдүүлэлтийн үйл ажиллагааны дагуу хийх ажлын төлөвлөгөөг гарган газрын даргаар батлуулан, тасгийн дарга нарт хүргүүлж, хэрэгжилтийг хангуулах чиглэлээр удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажилласан.

Төлөвлөгөөнд тусгагдсан хөтөлбөрийг алба хаагчдад сурталчлан таниулах, авилгын эсрэг үйл ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр аймгийн Хууль, эрх зүйн хэлтэстэй хамтран “Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөр”, “Авилгаас урьдчилан сэргийлэх нь” зэрэг сэдвүүдээр тус газрын 78 алба хаагчдад 1 удаагийн 1:30 цагийн, хэсгийн төлөөлөгч, цагдаа нарын цугларалтын үеэр 2 удаа 3 цагийн сургалтыг зохион байгуулсан. АТГ-аас орон нутгийн ЭБАТ-уудад зохион байгуулагдсан эрх бүхий албан тушаалтнуудад зориулсан 1 удаагийн 3 цагийн цахим сургалтад Захиргааны удирдлагын тасгийн дарга, хүний нөөцийн мэргэжилтэн нарыг хамруулсан. Цагдаагийн алба хаагчийн сахилга, ёс зүй, авилга, хээл хахууль, хүнд суртал, байгууллага, алба хаагчийн үйл ажиллагаатай холбоотой гомдол, хууль тогтоомж зөрчсөн тухай мэдээллийг ЦЕГ-ын 126, Цагдаагийн газрын 7044102, 70194100, 70194101, 89330002 дугаарын утсаар 24 цагаар хүлээн авч байгаа талаар зурагт хуудсыг орон нутгийн “Мазаалай” телевизээр сурталчлан Цагдаагийн газрын хүлээлгийн танхим, цагдаагийн хэсгийн байруудад байршуулсан. Алба хаагчдын шударга байдал, түүнийг нэмэгдүүлэх зорилгоор байгууллагын сургагч багшаас “Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм”, “Сахилгын дүрэм”-ээр 2 удаагийн 4 цагийн сургалт орж, 18 асуулт бүхий тестээр 1 удаа шалгалт авч, “Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм”, “Сахилгын дүрэм”-ээр танин мэдэхүйн асуулт хариултын /АХА/ тэмцээнийг зохион байгуулсан. Байгууллагын хэмжээнд авилгагүй бүсийг нэвтрүүлэн ажилласнаар энэ хугацаанд алба хаагчдаас авилгын сэжигтэй тохиолдол болон авилга өгөхөөр оролдсон, санал болгосон тохиолдол бүртгэгдээгүй.

ЦЕГ-ын дэд даргын 2018 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 4/823 дугаартай албан бичгээр ирүүлсэн ажлын чиглэлийн дагуу 2 удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулж, үүрэг ажлын чиглэлийг танилцуулж, дээрх төрлийн зөрчил дутагдлыг гаргахгүй ажиллах талаар 96 алба хаагчдаар нотломж үйлдэж, гарын үсэг зуруулан баталгаа авсан.

Нийт алба хаагчдыг “Ёс зүйн зөвлөл”-ийн гишүүдэд 7-8 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр баг болгон хувааж, бүтэн жилийн хугацаанд тус багийн дотоод зохион байгуулалт, зохион байгуулсан ажил, арга хэмжээ, багийн гишүүдийн биеэ авч явах байдал, сахилга, ёс зүйн зөрчилд холбогдсон эсэх үзүүлэлтүүдийг харгалзан үзэж, байр эзлүүлэн шагнаж, урамшуулахаар шийдвэрлэсэн.

“Гэр бүлийн өдөр”-ийг тохиолдуулан “Өнөр гэр бүл”, “Дархан бэр”, “Ханьдаа барих миний бэлэг” арга хэмжээг зохион байгуулж, 5 хүүхэд өсгөн хүмүүжүүлж

байгаа шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах ажил хариуцсан ахлах байцаагч, цагдаагийн хошууч Г.Баднааванчингийн гэр бүлийг “Өнөр гэр бүл”-ээр, 3 хүү дарааллан төрүүлж, өсгөн хүмүүжүүлж байгаа зохицуулагч, цагдаагийн дэслэгч С.Наран-Амгалан, эрүүгийн мөрдөгч, цагдаагийн ахмад Ч.Чинзоригийн эхнэр Б.Мөнхцацрал нарыг “Дархан бэр”-ээр шалгаруулж, дурсамж, дурсгалын зүйлээр шагнасан. Мөн “Ханьдаа барих миний бэлэг” арга хэмжээний хүрээнд алба хаагчдын дунд азтан шалгаруулж, азтан болсон 5 алба хаагчийн гэр бүлийн гишүүдэд дурсгалын зүйл гардуулж өгсөн.

Цагдаагийн газрын ахлагч нарын зөвлөлөөс “Цэрэгжилч, жагсаалч байдлыг сайжруулах” сарын аяныг зохион байгуулж, арга хэмжээний хүрээнд алба хаагчид дүрэмт хувцасыг дүрмийн дагуу цэвэр үзэмжтэй өмсөх, цэрэгжилч жагсаалч байдлыг хэвшүүлэх, алба хаагчид бие биедээ хүндэтгэлтэй хандах хандлагыг төлөвшүүлсэн. Арга хэмжээний хүрээнд цэрэгжилч жагсаалч байдлыг чанд сахин бусдыгаа хошуучлан ажилласан 5 алба хаагчийг шалгаруулж, өргөмжлөл мөнгөн шагналаар шагнасан.

Алба хаагчдын цэрэгжилч жагсаалч байдлыг сайжруулах зорилгоор Зэвсэгт хүчний 339 дүгээр ангийн холбооны тасгийн дарга, ахмад Г.Отгонбаяраар “Цэргийн алба хаагчдын жагсаалын дүрэм” сэдэвт 1 удаагийн 30 минутын сургалтыг зохион байгуулсан.

Мөн цаашид сахилга, ёс зүйн зөрчил, дутагдал гаргаж болзошгүй алба хаагчдыг сонгон авч, тэдгээртэй ярилцлага зохион байгуулж, тэднийг сахилгын зөрчил холбогдохоос урьдчилан сэргийлэх чиглэлээр “Зөвлөмж” өгч, нотломж үйлдэн, сахилгын зөрчил гаргаж, сахилгын арга хэмжээ авагдсан 31 алба хаагчидтай сэтгэл зүйчээс уулзалт ярилцлага зохион байгуулж, дүгнэлт гаргасан.

Тус газрын алба хаагчдаас энэ оны эхний 9 сарын байдлаар давхардсан тоогоор нийт 30 алба хаагч сахилгын зөрчил гарган арга хэмжээ авагдсанаас офицер 24, ахлагч 6 байна.

Сахилгын зөрчил гаргасан алба хаагчид нийт бие бүрэлдэхүүний 22.3 хувийг эзэлж, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад сахилгын зөрчил 5 нэгжээр буюу 20.0 хувиар өссөн.

Сахилга, ёс зүйн зөрчлийг хэлбэрээр авч үзвэл ажлын хариуцлага алдсан 17, архи дан согтуурсан 7, ажил тасалсан 3, Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм зөрчсөн 3 зөрчил байна. Үүнээс 18 алба хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалинг бууруулах, 8 алба хаагчид сануулах, 1 алба хаагчийн цол бууруулах, 3 алба хаагчийг Цагдаагийн албанд албанд нэг жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах сахилгын шийтгэлийг тус тус оногдуулж, тухайн байгууллагын дотоод хяналтаар 12, ёс журмын хяналтаар 2, гадны хяналтаар 3, иргэд, байгууллагын мэдээллээр 13 зөрчлийг илрүүлсэн.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Сахилгын шийтгэл оногдуулах” журам /код-914/-ын 914.52-д заасны дагуу мэдээг сар бүр ЦЕГ-ын Хүний нөөцийн хэлтэст хүргүүлж ажилласан. Мөн алба хаагчдын ажлын цаг ашиглалтын судалгааг гаргаж, ажлын цаг ашиглалт хангалтгүй, сахилга ёс зүйн зөрчилд холбогдох магадлалтай 15 алба хаагчидтай ганцаарчлан уулзаж, зөвлөгөө өгч ажилласан.

Алба хаагчдын сахилга хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор “Цагдаагийн алба хаагчийн сахилга, ёс зүйн дүрмийг хэн сайн мэдэх вэ?” танин мэдэхүйн

“Алтан хонх” тэмцээнийг зохион байгуулж, алба хаагчдад “Цагдаагийн алба хаагчийн сахилга, ёс зүйн дүрэм”-ийг өврийн ном хэлбэрээр хэвлүүлэн тараасан.

Алба хаагчдыг сэтгэц, зан үйлийн эмгэгээс урьдчилан сэргийлэх, стресс, бухимдал тайлах, сэтгэл хөдлөлөө хянаж зохицуулах, зөв амралт, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, мэдлэгийн түвшинг дээшлүүлэх зорилгоор алба хаагч, тэдний гэр бүлийн гишүүдэд сэтгэл зүйч, доктор Г.Наранбаатарын “Үнэхээр”, Монгол өрх сэтгэл зүйн хүрээлэнгийн захирал доктор Б.Баасанбатын “Бүлэг хамт олны уур амьсгалыг сайжруулах нь” лекцүүдийг уншуулсан.

Хамт олны халуун дулаан уур амьсгалыг бэхжүүлэх, нөхөрсөг, найрсаг уур амьсгалыг бүрдүүлэх зорилгоор “Эмэгтэйчүүдийн зөвлөл”-өөс алба хаагчдын төрсөн өдрийн судалгааг гаргаж, тухай бүрт нь алба хаагчдын төрсөн өдрийг тэмдэглэн, баяр хүргэн дуу дуулах, бялуу хуваах, төрсөн өдөр нь ажлын өдрөөр тохиож буй алба хаагчид ажлын 4 цагийн цалинтай чөлөөг олгох зэргээр хамтдаа тэмдэглэж хэвшсэн. Эхний хагас жилд сард 113 алба хаагчийн төрсөн өдрийг тэмдэглэн, төрсөн өдөр нь ажлын өдөр тохиосон 44 алба хаагчид 4 цагийн цалинтай чөлөө олгосон.

Тус газраас “Цагдаагийн газрын 2018 оны албаны сургалтын төлөвлөгөө”-нд тусгагдсаны дагуу алба хаагчдын албан үүрэг гүйцэтгэх чадварыг дээшлүүлэх энэ оны эхний 9 сарын байдлаар 101 сургалт төлөвлөгдснөөс 101 удаагийн сургалт хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу зохион байгуулагдаж, давхардсан тоогоор 7272 алба хаагч хамрагдсан нь сургалтын явц 100 хувьтай явагдаж байна.

Нэгдсэн хичээлээр нийт 95 удаагийн 209 цагийн сургалтад давхардсан тоогоор 1860 алба хаагчдыг, мэдвэл зохих хууль тогтоомжийн 12 удаагийн 12 цагийн сургалтад давхардсан тоогоор 1068 алба хаагчдыг, алба хаагчийг хөгжүүлэх 21 удаагийн 21 цагийн сургалтад “давхардсан тоогоор 1869 алба хаагчдыг, мэргэжлийн ур чадварын болон дадлагажуулах 15 удаагийн 18:30 цагийн сургалтад давхардсан тоогоор 1335 алба хаагчдыг, алба хаагчдын бие бялдарыг хөгжүүлэх, бэлтгэлжилтийн түвшинг нэмэгдүүлэх, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор 26 удаагийн 78 цагийн бие бялдар, өөрийгөө хөгжүүлэх чиглэлийн сургалтад давхардсан тоогоор 1892 алба хаагчдыг тус тус хамруулсан.

Нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, хууль бус жагсаал, цуглааны үеэр хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, албадан тараах талаар хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх, ЦБҮА журам /код 500, 502/-ын биелэлтийг хангах, алба хаагчдад мэргэжлийн дадлага, чадвар эзэмшүүлэх зорилгоор 2018 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр Хууль сахиулахын их сургуульд хүсэлт уламжлан, Ахлагчийн сургуулийн Тактик, тусгай бэлтгэлийн тэнхимийн эрхлэгч, цагдаагийн дэд хурандаа Г.Мөнхбат, Хил хамгаалах албаны тэнхимийн багш ахмад Д.Банзрагч нарыг урьж, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, хууль бус жагсаал, цуглааны үед ашиглагдах хамгаалах болон нэг бүрийн тусгай хэрэгслийн бүрэн бүтэн байдалд үзлэг хийж, түүнийг алба хаагч нар өмсөж хэрэглэх, хадгалах талаар сургалт зохион байгуулсан.

Алба хаагчдыг сургаж, дадлагажуулах, мэргэшүүлэх чиглэлээр “Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх 2018 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөө, хөтөлбөр”-ийн дагуу энэ оны эхний 9 сард зохион байгуулагдах сургалтад хамрагдах алба хаагчдын нэрсийг тасгуудаас авч нэгтгэн,

Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвд хүргүүлж, хуваарийн дагуу 76 алба хаагчийг сургалтад хамруулсан.

Мөн 1 алба хаагчийг хүний нөөцийн чиглэлээр Удирдлагын академийн зайны сургалтад, 1 алба хаагчийг Улсын Ерөнхий архивын албан хэрэг хөтөлөлтийн сургалтад хамруулсан.

Тус газраас хамтран ажиллах гэрээний хүрээнд “Орхон” их сургуулийн магистрын сургалтад 6, “Улаанбаатар эрдэм” дээд сургуулийн эчнээ эрх зүйн ангид 5 алба хаагийг эрх зүйн чиглэлээр өдөр, эчнээ ангийн сургалтуудад алба хаагчдыг, мөн Хууль сахиулахын их сургуулийн эчнээ 5 жилийн хөтөлбөрийн сургалтад 1, эчнээ 3 жилийн сургалтын хөтөлбөрт 7 алба хаагчийг хамруулж, суралцах нөхцөл бололцоогоор хангасан.

Цагдаагийн газарт энэ оны эхний 9 сарын байлаар ахлагчийн сул орон тоонд шинээр томилогдсон 7 алба хаагчийг ажил албанд нь богино хугацаанд сургах, мэргэжлийн чиг баримжаатай болгох зорилгоор дасан зохицох хөтөлбөрийг дадлагажуулагч багш нараас гарган Газрын даргаар батлуулан, холбогдох хууль эрх зүйн акт, албан тушаалын заавар, эрх, үүрэг, ажлын байрны тодорхойлолттой танилцуулан, албаны баталгаа гаргуулж, 3 жилийн хугацаанд тогтвор суурьшилтай ажиллах гэрээ байгуулж, үүрэг гүйцэтгүүлж байна.

Сургалтын материаллаг баазын хувьд ЦЕГ-аас болон харъяа албад мэргэжлийн байгууллага, багш нараас гаргасан сургалтын аудио, видео бичлэг, кино, лекц, бодлого, сурах бичиг, гарын авлага, танилцуулга материал, зайн сургалтын материалуудыг тус тус ашиглан явуулсан.

Тус газар нь байгууллагынхаа 78 м² талбай бүхий өрөөг хурлын болон сургалтын танхим болгон ашиглаж, сургалтын үйл ажиллагаанд зөөврийн ACER компьютер 1 ширхэг, проектор 1 ширхэг, телескоп 1 ширхэг, зөөврийн дэлгэц 1 ширхэг, дижитал аппарат 1 ширхэг, шохойн хэрэглүүр бүхий 1 самбар ашигладаг.

Цагдаагийн алба хаагчдын чөлөөт цагийг гэр бүлийн гишүүдийн хамт зөв боловсон өнгөрүүлэх, гэр бүлдээ цаг зав зарцуулах, танин мэдэхүйн мэдлэгийг дээшлүүлэх, ажлын ачаалал, стресс ядаргааг тайлах болон Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 А/82 дугаар тушаалаар батлагдсан “Соён гэгээрүүлэх ажил зохиох” журам /код 940/-ын 940.2.1-д заасны дагуу газрын бие бүрэлдэхүүний дунд соёлын үйл ажиллагаа явуулах, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах чиглэлээр ажлын 14 заалт бүхий төлөвлөгөөг гарган батлуулж, биелэлт, үр дүнг тооцон ажилласан.

Алба хаагчдын ерөнхий мэдлэгийн төвшинг дээшлүүлэх, өөрийгөө бусдад илэрхийлэх, ярих, илтгэх урлагийг эзэмшүүлэх, аливаа мэдээллийг олж, дүн шинжилгээ хийх чадвар эзэмшүүлэх зорилгоор өглөө бүрийн шуурхай яриан дээр дотоодын болон гадаад орнуудын улс төр, нийгэм, эдийн засаг, танин мэдэхүйн бусад мэдээлэл, шинжлэх ухаан, техник, технологийн ололтын талаар 132 удаа, давхардсан тоогоор 9470 алба хаагчдад мэдээлэл хийсэн.

Америкийн нэрт зохиолч Норман Винсент Пилийн “Өдөр бүх өөдрөгөөр сэтгэх нь” номыг танилцуулах хуваарь гарган алба хаагч нэг бүрээр хийлгэх ажлыг хэвшил болгон явуулснаар тайлангийн хугацаанд давхардсан тоогоор 93 удаа, тоогоор 7440 алба хаагчдад дээрх чиглэлийн мэдээллийг хийжээ. Алба хаагчдын албаараа, өөрөөрөө, хамт олноороо бахархах сэтгэгдлийг нэмэгдүүлэх, бусдаас суралцах, өөрийгөө илэрхийлэх ур чадварыг сайжруулах зорилгоор “Миний

бахархал” сэдвийн хүрээнд өглөөний ярианы дараа 5-10 минутын ярилцлага зохион байгуулсан.

Алба хаагч, ажилтнуудын бие бялдарыг хөгжүүлэх, Цагдаагийн ерөнхий газраас зохион байгуулагдах тэмцээн уралдаанд баг тамирчдын бэлтгэлийг хангуулах зорилгоор 13 заалт бүхий тэмцээн уралдааны төлөвлөгөө гарган, хуваарийн дагуу “Ахлагч нарын зөвлөл”-ийн нэрэмжит “Мөсний баяр”, хэсгийн төлөөлөгч нарын нэрэмжит “Сагсан бөмбөг”, Замын цагдаагийн тасгийн нэрэмжит “Сагсан бөмбөг”, Эрүүгийн цагдаагийн тасгийн нэрэмжит “Хөл бөмбөг”, Захиргааны удирдлагын тасгийн нэрэмжит “Гар бөмбөг”, Мөрдөн байцаах тасгийн нэрэмжит “Олс таталт”, Нийтийн хэв журам хамгаалах тасгийн нэрэмжит “Хөгжөөнт буухиа”, хэсгийн цагдаа нарын нэрэмжит “Гар бөмбөг”-ийн тэмцээнийг зохион байгуулсан. Архангай аймагт зохион байгуулагдсан “Хангайн бүсийн Цагдаагийн газрын алба хаагчдын спортын наадам”-д тус газрын баг тамирчид амжилттай оролцож, нийлбэр дүнгээр “Тэргүүн байр”-т, Цагдаагийн ерөнхий газраас зохион байгуулагдсан 5 төрлийн уралдаан тэмцээнд 4 алба хаагч шагналт байрт шалгарсан амжилтуудыг тус тус үзүүлсэн.

Сар шинийн баярыг тохиолдуулан тус газарт ажиллаж байгаад тэтгэвэрт гарсан 40 ахмад настнуудыг хүлээн авч хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг энэ оны 2 дугаар сард 1 удаа зохион байгуулж, арга хэмжээ болон гарын бэлгэнд 1,520,000 төгрөгийг зарцуулсан. Арга хэмжээний үеэр ахмадуудад 2017 онд хэрэгжүүлсэн онцлог ажлуудаас танилцуулж, тэдний санал хүсэлтийг хүлээн авч, уламжлалт шагайн наадгайн тэмцээн зохион байгуулж, ахмад настуудад гарын бэлэг гардуулсан. Хамгийн өндөр настай 1 ахмад настанд 108,000 төгрөгийн тусламж үзүүлэн, хамгийн өндөр настай 3 ахмадын ажил амьдралын түүх, ажлын туршлагын талаар нийт 78 алба хаагчдад мэдээлэл хийлгэж, харилцан яриа өрнүүлсэн.

Олон улсын ахмадын баярын өдрийг тохиолдуулан 09 сарын 27 нд аймгийн “Ахмадын ордон”-д ахмадууддаа хүлээн авч хүндэтгэл үзүүлэх ажлыг зохион байгуулан, арга хэмжээ гарын бэлгэнд нийтдээ 1,125,500 төгрөгийг зарцууллаа.

Арга хэмжээний үеэр “аймгийн тэргүүний ажилтан” цол тэмдгээр

2, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын “Соёрхол тэмдэгээр” 2, аймгийн Засаг даргын жуух бичгээр 1, Баянхонгор сумын засаг даргын жуух бичгээр 2, иргэдийн төлөөлөгчдийн хурлын жуухаар 2 ахмад настан тус тус шагнагдсан.

“Монголын хурандаа нийгэмлэг”-ийн удирдлага, удирдах зөвлөлийн зарим гишүүдийг хүлээн авч хүндэтгэл үзүүлэн алба хаагчдад сургамж, зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх арга хэмжээг 2018 оны 06 дугаар сард зохион байгуулж, хурандаа Ч.Баатар, цагдаагийн хурандаа Ц.Алтанцэцэг нар алба хаагчидтай уулзан эх оронч хүмүүжил ахмад үеэ хайрлах, тэднээс суралцах талаар 1 удаагийн 1 цагийн лекц яриа хийж, 76 алба хаагчдыг хамруулсан.

Цагдаагийн ерөнхий газрын даргын болон Цагдаагийн газрын даргын тушаалаар цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгохоор албанаас чөлөөлөгдсөн 7 ахмадуудыг 2018 оны 09 сарын 20-ны өдөр хүлээн авч, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны /код 933.6/ журамд заасны дагуу хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг зохион байгуулсан.

ЦЕГ-ын “Авлигаас урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн 2018 онд хийх ажлын төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг хангах чиглэлээр 31 заалт бүхий ажил, арга

хэмжээний салбар төлөвлөгөө боловсруулан батлуулж, биелэлтийг хангуулах чиглэлээр удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авч, биелэлт үр дүнг тооцон, Авлигын эрсдлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2018 оны төлөвлөгөөний эхний хагас жилийн биелэлтийг гаргаж, 2018 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 33-1/1885 дугаартай албан бичгээр Аюулгүй байдлын хэлтэст хүргүүлсэн.

Алба хаагчдын 2018 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн бүрдүүлэлтийн үйл ажиллагааны дагуу хийх ажлын төлөвлөгөөг гарган газрын даргаар батлуулан, тасгийн дарга нарт хүргүүлж, хэрэгжилтийг хангуулах чиглэлээр удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажилласан.

Алба хаагчдын 2018 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн бүрдүүлэлтийн үйл ажиллагааны дагуу хийх ажлын төлөвлөгөөг гарган газрын даргаар батлуулан, тасгийн дарга нарт хүргүүлж, хэрэгжилтийг хангуулах чиглэлээр удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажилласан.

Тус газраас Монгол Улсын Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу ЦЕГ-ын дэд даргаас 2018 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 4/39 тоот албан бичгээр ирүүлсэн үүрэг, ажлын чиглэлийн дагуу хийх ажлын төлөвлөгөөг батлуулсан.

Монгол Улсын Хууль зүйн байнгын хорооны 2014 оны 20 дугаар тогтоолоор “Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах албан тушаалтны жагсаалт”-д заагдсан албан тушаал эрхэлж буй нийт 69 алба хаагчдыг хамруулан хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг www.meduuleg.iaac.mn цахим хаягаар авч нийт 69 алба хаагчийн мэдээллийг баталгаажуулан ажиллалаа. Мэдүүлгийн бүрдүүлэлтийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу хөдөө сумдад ажиллаж байгаа сум дундын цагдаагийн тасгийн дарга, хэсгийн төлөөлөгч нарын сургалт цугларалтыг 2018 оны 02 дугаар сарын 05-ны өдөр зохион байгуулж, “Хөрөнгө, орлогын мэдүүлгийг мэдүүлэх аргачлал” сэдвээр 1 удаагийн 1 цаг 30 минутын сургалтыг онолын болон дадлага хэлбэрээр зохион байгуулж, ХАСХОМ-ийг мэдүүлэх нөхцөл боломжоор ханган, ажлыг удирдлага, зохион байгуулалтаар ханган ажилласан.

Цагдаагийн алба хаагчийн сахилга, ёс зүй, авлига, хээл хахууль, хүнд суртал, байгууллага, алба хаагчийн үйл ажиллагаатай холбоотой гомдол, хууль тогтоомж зөрчсөн тухай мэдээллийг ЦЕГ-ын 126 дугаарын тусгай утсаар 24 цагаар хүлээн авч байгаа талаар зураг хуудсыг орон нутгийн “Мазаалай” телевизээр сурталчилан Цагдаагийн газрын хүлээлгийн танхим, цагдаагийн хэсгийн байруудад хэвлүүлэн байршуулсан. Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн авлига, ашиг сонирхлын зөрчил, албан тушаалын гэмт хэрэг, төрийн байгууллага, албан тушаалтны хүнд сурталын талаарх мэдээллийг 1800-1969 дугаарын утсаар хүлээн авч байгаа талаар видео бичлэгийг орон нутгийн телевиз, байгууллагын иргэдийг хүлээн авах танхимд байрлах зурагт самбарт мэдээллийг байршуулан иргэдэд хүргэх ажлыг зохион байгуулан ажилласан.

Иргэдийг хүлээн авах уулзалтын танхимд байгууллагын удирдлагууд болон тухайн өдрийн ёс журам сахиулах эргүүлүүд иргэдийг хүлээн авч уулзах цагийн

хуваарийг шинэчлэн баталж, иргэдээс Цагдаагийн байгууллагын болон алба хаагчдын үйл ажиллагаатай холбогдуулан 49 санал хүсэлтийг хүлээн авч, холбогдох албан тушаалтнаар шийдвэрлүүлэн ажилласан. Уг танхимд тасаг бүр өөрсдийн үйл ажиллагааг сурталчилсан мэдээллийг байршуулан дээрх үйл ажиллагаанд удирдлагын зүгээс биечлэн хяналт тавьж ажилласан.

Байгууллагын хэмжээнд авлигагүй бүсийг нэвтрүүлэн ажилласнаар энэ хугацаанд алба хаагчдаас авлигын сэжигтэй тохиолдол болон авлига өгөхөөр оролдсон, санал болгосон тохиолдол бүртгэгдээгүй.

Дөрөв: Санхүүгийн бүртгэл, хангамж үйлчилгээний талаар

Тус газар нь 2018 онд нийт 1,927,467,2 мянган төгрөгийн төсөв батлагдаж, 2 дугаар улирлын байдлаар 947,074,6 мянган төгрөгийн санхүүжилт, үндсэн үйл ажиллагааны орлогоос 31,827,5 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлэн нийт 978,902,1 мянган төгрөгийн орлоготой, 964,980,0 мянган төгрөгийн зардал зарцуулж, батлагдсан төсвийг зориулалтын дагуу холбогдох хууль, журам, зааврын дагуу зарцуулан ажилласан.

Тайлант хугацаанд цалингийн зардалд 797,580,9 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлд 16,932,8 мянган төгрөг, түлш халаалтын зардалд 54,727,6 мянган төгрөг, гэрэл цахилгааны зардалд 5,365,9 мянган төгрөг, цэвэр бохир усны зардалд 6,258,7 мянган төгрөг, шатах тослох материалын зардалд 41,960,1 мянган төгрөг, шуудан холбооны зардалд 3,686,3 мянган төгрөг, алба хаагчдын дотоод албан томилолтын зардалд 8,402,5 мянган төгрөг, бичиг хэргийн зардалд 6,843,4 мянган төгрөг, урсгал засварын зардалд 9,411,1 мянган төгрөг, хоолны зардалд 10,946,6 мянган төгрөг, хөдөлмөр хамгаалалын хэрэгслийн зардалд 283,5 мянган төгрөг, эмийн зардалд 225,0 мянган төгрөг, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлийн зардалд 1,150,2 мянган төгрөг, тээврийн хэрэгслийн татвар, оношлогоонд 742,4 мянган төгрөг, хичээл үйлдвэрлэлийн зардалд 463,0 мянган төгрөгийг тус тус зарцуулж нийт 964,980,0 мянган төгрөгийн зардал гаргаж шинээр авлага үүсээгүй ажилласан.

Байгууллагын 2018 онд батлагдсан төсвийн дагуу байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдах бараа материалыг нийлүүлэх аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг газрын даргын 2018 оны 01 сарын 10-ны өдрийн А/10 дугаар тушаалаар томилогдсон гишүүд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 33 дугаар зүйлд заасны дагуу харьцуулалтын аргыг хэрэглэж, төрийн худалдан авах ажиллагааны цахим системд урилгыг байршуулан үр дүнг нийтэлсэн.

Хуулийн дагуу орон нутагт үйл ажиллагаа явуулдаг “Баянхонгор эко дулаан” ХХК, “Тод од сод” ХХК, “Явуухэлхээ” ХХК, “Монгол шуудан” ХК-уудтай бараа материал нийлүүлэх гэрээ байгуулсан.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу 2018 онд 82,0 сая төгрөгийн үнийн саналаар худалдан авах шатахуун тослох материалыг нийлүүлэх аж ахуй нэгжийг сонгон шалгаруулах тендерийн үйл ажиллагааг аймгийн Орон нутгийн өмчийн газраас зохион байгуулж, хуулийн хугацаанд аж ахуйн нэгжүүд тендерийн материал

ирүүлээгүй тул аймгийн засаг даргын тамгын газраас 2018 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн б/70 дугаартай албан бичгээр гэрээ шууд байгуулах талаар зөвлөмж ирүүлсэний дагуу “Ник” ХХК-тай шатахуун, тос тослох материал нийлүүлэх гэрээ байгуулсан.

2019 оны төсвийн төслийг боловсруулан баталгаажуулан ЦЕГ-ын Санхүү аж ахуйн албанд хүргүүлэн ажилласан.

2018 оны батлагдсан төсвийн хуваарь, байгууллагын үйл ажиллагаа, хөрөнгө зарцуулахтай холбогдон гарч байгаа тушаал, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалт, үндсэн үйл ажиллагаанаас орж байгаа орлогын төлөвлөгөө, худалдан авах үйл ажиллагааны тайлан гэрээ зэрэг мэдээ мэдээллүүдийг цахимаар болон файл хэлбэрээр шилэн дансны <http://shilendans.gov.mn/> сайтад тогтмол байршуулсан.

ЦЕГ-ын даргын 2014 оны 164 дүгээр тушаалаар батлагдсан “Байгууллагын ил тод байдлыг хангах /код 135/ журам”-ын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд төсвийн орлого ба зарцуулалтын мэдээ, тайлангуудыг хугацаанд нь гаргаж, шилэн дансны <http://shilendans.gov.mn> сайтад тогтмол байршуулан нийт 45 нэр төрлийн 809,1 сая төгрөгийн орлого, 97,9 сая төгрөгийн зарлагын ажил гүйлгээнүүдийг байршуулсан. Төсвийн орлого зарцуулалт болон тайлагналын үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй болгох ажлыг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулж, Шилэн дансны мэдээллийн нэгдсэн сайтад төсвийн орлого ба зарцуулалтын мэдээ, 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын байгууллагаас Цагдаагийн газрын санхүүгийн тайлан балансад үзүүлсэн аудитын итгэмжлэл, төсвийн хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан, тайлбар, байгууллагын үйл ажиллагаа, хөрөнгө зарцуулахтай холбогдон гарч байгаа тушаал, худалдан авах үйл ажиллагааны тайлан, гэрээ зэрэг мэдээ мэдээллүүдийг тухайн бүр байршуулж ажилласан.

Саатуулагдсан болон баривчлагдсан хүмүүсийн төлбөр төлөлтөд хяналт тавьж, сар бүр тайланг хүлээн авч харилцахын хуулгатай тулган баталгаажуулж нийт 9,666,5 мянган төгрөгийн төлбөрийг байгууллагын 100030012001 тоот дансанд төвлөрүүлэн ажилласан.

Тав: Алба хаагч, ажилтны ажиллах нөхцөл, нийгмийн асуудлыг хангах, эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр

ЦЕГ-ын даргын 2016 оны Б/302 дугаар тушаалаар батлагдсан “Цагдаагийн алба хаагч, ажилтны нийгмийн баталгааг хангах, эрүүл мэндийг хамгаалах” хөтөлбөрийн хүрээнд алба хаагчдын ажиллах урам зориг, ар гэртээ зарцуулах цаг завьг нэмэгдүүлэх, тэдэнд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх, дэлгэрэнгүй судалгаатай болох зорилгоор 16 асуулт бүхий санал асуулгыг алба хаагч, тэдний гэр бүлийн гишүүдээс авч нэгтгэн, үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Тус газрын удирдлагаас сумдын хэсгийн мөрдөгч, цагдаа нарын амьдрал ахуйтай танилцаж, алба хаагчдын гэр бүлийн гишүүдийг ажлын байраар хангах, байрны засвар үйлчилгээг шийдвэрлүүлэхээр Цагдаагийн албаны тухай хуулийн 94 дүгээр зүйлд заасныг удирдлага болгон 2 сумын Засаг дарга нарт хүсэлт хүргүүлсэн. Энэ онд алба хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор

олон жил тогтвор суурьшилтай, хөдөө сумдад ажилласан 10 алба хаагчид аймгийн төвд эзэмшлийн газар өмчлүүлэх асуудлыг тусгуулж шийдвэрлүүлсэн.

Цагдаагийн газрын 89 алба хаагчдын гэр, орноор орж, ахуй амьдралтай нь танилцаж, санал хүсэлтийг хүлээн авч, 25 алба хаагчдад хямдралтай үнээр 20 тн нүүрс, 28 ахмадад тус бүр 2 тн нүүрс үнэгүй олгож, орон сууцны болон бусад зээлд хамрагдах хүсэлт гаргасан давхардсан тоогоор нийт 149 алба хаагчдад цалингийн тодорхойлолтыг нь гаргаж өгсөн.

Газрын дарга болон даргын зөвлөлийн гишүүдээс алба хаагчдын ажиллаж, амьдрах нөхцөл бололцоог сайжруулах, санал хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх, сахилга ёс зүйн зөрчил, дутагдал гаргахгүй байхад анхаарах, тулгарч буй аливаа асуудлыг судлан тодруулж, шийдвэрлэх зорилгоор 35 алба хаагчдын гэрээр орж нөхцөл байдалтай танилцан, алба хаагчдаас амаар болон бичгээр 2 удаа судалгаа аван, давхардсан тоогоор 175 гаруй алба хаагчдыг хамруулсан. Алба хаагчдын гэр бүлийн гишүүдийг 2 удаа цуглуулан газрын удирдлагаас уулзалт зохион байгуулж, гэр бүлийн гишүүдийн зөвлөлийг шинэчлэн байгуулж, гэр бүлийн зөвлөлийн ажиллах журмыг баталсан.

Алба хаагч болон гэр бүлийн гишүүдээс гаргасан санал, хүсэлтийг үндэслэн 8 алба хаагчийг хөнгөлөлттэй үнээр орон сууцанд оруулах, гэр бүлийн 1 гишүүнийг эмчилгээнд хамруулах, 1, алба хаагчийн гэр бүлийн гишүүнийг ажлын байраар хангах цэргийн байнгын тэтгэвэрт гарсан 3 ахмад ажилтанг үнэ төлбөргүйгээр эмчилгээ сувилгаанд хамруулах ажлыг зохион байгуулсан.

Хөдөө сумдад ажиллаж байгаа 2 алба хаагчийн гэр бүлийн гишүүнийг ажлын байраар хангах чиглэлээр холбогдох байгууллагуудад хүсэлтийг уламжилсан.

Тус газрын алба хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулах төлөвлөгөө гарган батлуулж, аймгийн Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэгтэй 2018 онд хамтран ажиллах “Санамж бичиг” байгуулан, алба хаагчдын эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлэгтэй хамтран 2018 оны 04 дүгээр сарын 20, 23-ны өдөр 4 төрлийн шинжилгээнд 76 алба хаагчдыг хамруулж, “Дотор”, “Мэдрэл”, “Эмэгтэйчүүд”, “Зүрх судас”, “Арьс өнгө”-ний нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгт хамруулж, “Элэгний В,С вирус”-ыг эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэх шинжилгээнд хамруулан, Хепатит В вирусын халдвар илэрсэн 10 алба хаагч, С вирусын халдвар илэрсэн 3 алба хаагчдад эрүүл мэндийн зөвлөгөө өгч элэгний нарийн мэргэжлийн эмчид үзүүлж, вирусын идэвхижилтийг тоолуулах шинжилгээнд хамруулж, идэвхижилтийг тодорхойлсоноор эмийн эмчилгээнд үнэ төлбөргүй хамруулсан. Мөн алба хаагч, ажилтныг хеликобактерийн шинжилгээнд хамруулахад нийт 76 алба хаагч шинжилгээнд хамрагдсанаас 71 алба хаагч бактертай гарсан байгаа нь нийт шинжилгээнд хамрагдсан алба хаагчдын 93.1 хувийг эзэлж байна.

“Эрүүл мэндийн газар”, “Баянхонгор хайрхан фарм” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар, “Монос фарм”, “Номгон ариусал” ХХК зэрэг байгууллагуудтай хамтран 71 алба хаагчийг хөнгөлөлттэй үнээр эмчлүүлэх чиглэлээр удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авч, эмийг олгох ажлыг зохион байгуулсан.

Эмчилгээний үр дүнг сайжруулах зорилгоор тухайн өвчин нь ахуйн замаар халдварладаг тул ар гэрийн гишүүдийн дунд “Эрүүл мэндийн боловсрол олгох,

хеликобактерын өвчлөл, халдварлах зам, урьдчилан сэргийлэх” нь сэдвээр 2 цагийн сургалт зөвлөгөөн зохион байгуулж, Элэгний “В”, “С”, вирус, хеликобактер илрүүлэх шинжилгээнд ар гэрийн эмэгтэй 32, эрэгтэй 8, хүүхэд 6 нийт 46 хүнийг хамруулж, цаашид вирус тоолох шинжилгээ, эмчилгээнд хамруулах арга хэмжээг үе шаттай зохион байгуулж байна. Нэгдсэн эмнэлэгийн лабораторийн тасагтай хамтран Элэгний “В”, “С”-ыг үнэ төлбөргүй тоолуулах шинжилгээнд 8 алба хаагчийг хамруулж, нарийн мэргэжлийн эмчийн зөвлөгөө өгсөн.

ЗОНОЗ өвчин судлалын төвтэй хамтран “Тарваган тахал” өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинд 83 алба хаагчийг хамруулж, нэр бүхий 10 алба хаагчийг вакцины дархлааны шинжилгээ авч ажилласан.

Нэгдсэн эмнэлгийн сургалт хариуцсан мэргэжилтэн С.Бадамцэцэг, хоолны мэргэжилтэн Д.Мөнх-Эрдэнэ нартай хамтран “Элэгний В, С вирус”, “Хеликобактерын халдварлах зам, урьдчилан сэргийлэх”, “Хорт зуршлын хэрэглээ, тамхины хор уршиг”, “Томуу, томуу төст өвчний талаар ойлголт” “Давсны хэрэглээ”, “Эрүүл, Зөв хооллолт” сэдвүүдээр 8 удаа, “Эрүүл, зөв хооллолт” сэдвээр практик сургалтыг 1 удаа зохион явуулсан.

“Наран мандал” өрхийн эмнэлэгийн эмч Н.Өлзийжаргалтай хамтран Цагдаагийн газрын алба хаагчдын дунд зонхилон тохиолдох өвчлөл, тамхины хэрэглээний талаар судалгаа авахад, “Зүрхний цусан хангамжийн дутагдал” өвчнөөр өвчлөх нь 52,1 хувь, тамхины хэрэглээ нийт алба хаагчдын 93,2 хувьтай байна гэсэн дүгнэлт гарсан. Зүрхний цусан хангамжийн дутагдал өвчинд тамхины хэрэглээ нь хоёрдогч шалтгаан болж байна гэж үзэн “Тамхигүй орчин” аян өрнүүлж, “Зүрхний цусан хангамжийн дутагдал өвчний хам шинж, урьдчилан сэргийлэх”, “Хорт зуршлын хэрэглээ, тамхины хор уршиг” сэдвээр 4 цагийн сургалт зохион явуулсан. Мөн мэргэжлийн хяналтын хөдөлмөр аюулгүй байдлын улсын байцаагч Б.Гантуяатай хамтран Замын цагдаагийн тасгийн алба хаагчдын өвчлөлийг сүүлийн 3 жилээр гаргаж ажил мэргэжилээс шалтгаалсан өвчлөлөөр өвчилсөн эсэхэд дүгнэлт хийх ажиллыг эхлүүлэн ажиллаж байна.

Зургаа: Дотоод хяналтын хүрээнд

Байгууллага, алба хаагчдын аюулгүй байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, саармагжуулах чиглэлээр эрсдэлийн мэдээллийн санд баяжилт хийж, 2018 онд хэрэгжүүлэх эрсдэлийн төлөвлөгөөг газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулж, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

ЦЕГ-ын даргын 2018 оны баталсан “Цагдаагийн байгууллагын дотоод аюулгүй байдлыг хангах талаар хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөө”-ний хүрээнд тус газраас 7 бүлэг 24 заалт бүхий төлөвлөгөө боловсруулан газрын даргаар батлуулж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байгууллагын албаны нууцлал, аюулгүй байдлыг хангах төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулахаар 1 удаа гэнэтийн шалгалтыг зохион байгуулж, илэрсэн зөрчил дутагдлыг удирдлагад танилцуулан, зөрчлийг арилгах чиглэлээр зааварчилгаа өгсөн.

ЦЕГ-ын ДХШАБГ-аас энэ оны 03 дугаар сард байгууллагын аюулгүй байдлыг хангах чиглэлээр ирсэн шалгалт, ЦЕГ-ын даргын 2018 оны А/130 дугаар тушаалаар батлагдсан Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын үйл ажиллагаа алба хаагчдын мэргэшлийн түвшинг үнэлэх, шинээр батлагдсан хууль

тогтоомжуудын хэрэгжилттэй танилцах, сургалт зохион байгуулах чиглэлээр 2018 оны 05 дугаар сарын 30-ны өдөр ирсэн шалгалт, сургалтад амжилттай шалгагдсан.

Цагдаагийн газрын эрсдэлийн үнэлгээг газрын даргын тушаалаар томилогдсон Эрсдэлийн үнэлгээ хийх орон тооны бус багаас 2018 онд нийт А бүлгийн Төсөв санхүүгийн 10, Б бүлгийн Үйл ажиллагааны 38, В бүлгийн Нийцлийн буюу эрх зүй зохицуулалтын 8, Г бүлгийн Гадаад хүчин зүйлсийн буюу давагдашгүй зүйлсийн 6 эрсдэл нийт 62 эрсдэлийг бүртгэж, мэдээллийн санд оруулсан. Эрсдэлд тооцон бүртгэгдсэн ямарч тохиолдолд гарч байдаг, гарсан ч тухайн байгууллагын дотоод үйл ажиллагаанаас хамаарахгүй гадны хүчин зүйлсээс болж гардаг 21 эрсдэл /inherent/, байгууллага дотооддоо удирдаад арилгаж, бууруулж, урьдчилан сэргийлж болох 41 эрсдэл /residual/ байна.

Тасгийн дарга нараас Монгол Улсын Хууль зүйн сайдын 2015 оны А/238 дугаар тушаалаар батлагдсан журмын дагуу алба хаагчдаас гаргасан сахилга, ёс зүйн зөрчилд албаны шалгалтыг тал бүрээс нь бүрэн гүйцэт, бодитой явуулж, алба хаагчийн гаргасан зөрчлийн шалтгаан нөхцөлийг тогтоон, газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлж хэвшсэн.

Тус газрын 49 алба хаагчидтай холбоотой 39 гомдол, мэдээллийг хүлээн авч бүртгэн, гомдол, мэдээлэл бүрт ЦБҮАЖ “Байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалт зохион байгуулах” /код 112-д зааснаар албаны шалгалт явуулж, давхардсан тоогоор нийт 30 алба хаагчид сахилгын шийтгэл оногдуулж, хэрхэн шийдвэрлэсэн талаар хариуг хугацаанд нь хүргүүлсэн.

Иргэд, байгууллагаас цагдаагийн алба хаагчийн үйл ажиллагаатай холбогдуулан ирүүлсэн өргөдөл, гомдлын мэдээг сар бүр өссөн дүнгээр гаргаж, ЦЕГ-ын Аюулгүй байдлын хэлтэст хүргүүлэн ажилласан. Цаашид байгууллагын дотоод хяналтыг сайжруулах чиглэлээр ёс журмын эргүүлүүдийг 24 цагаар үүрэг гүйцэтгүүлэн, алба хаагчдын сахилга ёс зүйн байдалд тогтмол хяналт тавьж ажиллах талаар үүргийг өгсөн.

Долоо: Дүгнэлт

Тайлант хугацаанд гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх, бууруулах, таслан зогоох чиглэлээр “Хуулиа мөрдье 21”, “Сэрэмжлье нэгдэе”, “Хуулийн хэрэгжилт”, “Сар шинэ”, “Илрүүлэлт шийдвэрлэлт эрэн сурвалжлалт”, “Мотоцикль”, “Ноолуур”, хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх таслан зогсоох зорилгоор “Сар шинэ-аюулгүй тээвэр”, “Согтуу”, “Мотоциклийн бүртгэл”, “Хүүхэд хамгаалал”, “Бяцхан зорчигч”, “Хот хоорондын ачаа тээвэрлэлт”, “Орон нутгийн зам-хөдөлгөөний соёл”, аймгийн хэмжээнд согтуугаар үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлийг бууруулах, архины хор уршигийг иргэдэд тайлбарлан таниулах, согтууруулах ундаа худалддаг, түүгээр үйлчилдэг аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх чиглэлээр “Цагийн хуваарь”, “Камержуулалт”, “Хуулийн хэрэгжилт”, “Согтуу” зэрэг нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээнүүдийг зохион байгуулж, биелэлт үр дүнг тооцон үр дүнтэй зохион байгуулснаар гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг өмнөх оны мөн үетэй харьцуулахад адил түвшинд байна, гэмт хэргийн илрүүлэлт 2018 оны эхний 9 сард

47.7 хувьтай байсан бол арга хэмжээний үр дүнд 41 хувь болж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад хэргийн илрүүлэлт 8 пунктээр өссөн.

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлд аймгийн хэмжээнд сүүлийн 5 жилийн хугацаанд үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн мэдээллийг танилцуулж, шалтгаан нөхцөлийг судлах зорилгоор мэргэжлийн багаар дүгнэлт гаргуулахад шаардлагатай 10.000.000 төгрөгийн хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлж, 2018 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр “Монголын “Эрх зүйн хэлэлцүүлэг сэтгүүл” хэвлэл, мэдээллийн хэрэгслийн захирал Б.Гүнбилэгтэй гэмт хэрэг, зөрчлийн сүүлийн 5 жилийн гаралтын байдалд дүн шинжилгээ хийлгэхээр хамтран ажиллах гэрээг байгуулан, судалгааны ажил хийгдэж байна.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2018 оны 02 дугаар 14-ны өдөр өгсөн үүрэг, ажлын чиглэл, тэргүүн дэд дарга, дэд дарга нараас алба хаагчдын сахилга, ажлын хариуцлагыг сайжруулах чиглэлээр ирүүлсэн 2018 оны 4/1237, 4/1708, 5/49, 5/60, 5/78 тоот албан бичгээр ирүүлсэн ажлын чиглэл, үүргийг хэрэгжүүлэх зорилгоор тус бүр 5-16 заалт арга хэмжээ бүхий ажлын төлөвлөгөөнүүдийг тус тус гарган, ажлын чиглэл, үүргийг хэрэгжүүлэх, зөрчихгүй байх талаар 8 заалт бүхий баталгааг 93 алба хаагчдаас бичгээр гаргуулан авч, нийт алба хаагчдыг “Ёс зүйн зөвлөл”-ийн гишүүдэд 7-8 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр баг болгон хувааж, бүтэн жилийн хугацаанд тус багийн дотоод зохион байгуулалт, зохион байгуулсан ажил, арга хэмжээ, багийн гишүүдийн биеэ авч явах байдал, сахилга, ёс зүйн зөрчилд холбогдсон эсэх үзүүлэлтүүдийг харгалзан үзэж, байр эзлүүлэн шагнаж, урамшуулахаар шийдвэрлэсэн.

Сахилга, ёс зүйн зөрчил, дутагдал гаргаж болзошгүй алба хаагчдыг сонгон авч, тэдгээртэй ярилцлага зохион байгуулж, тэднийг сахилгын зөрчил холбогдохоос урьдчилан сэргийлэх чиглэлээр “Зөвлөмж” өгч, нотломж үйлдэн, сахилгын зөрчил гаргаж, сахилгын арга хэмжээ авагдсан 30 алба хаагчидтай сэтгэл зүйчээс уулзалт ярилцлага зохион байгуулж, дүгнэлт гаргасан.

Найм: Санал

1.Цагдаагийн байгууллагын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд туссан заалтын хэрэгжилтийг хангуулах,

2.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн гэмт хэрэг, зөрчлийн талаарх гомдол, мэдээллийн дагуу шуурхай очиж, хуульд заасан хойшлуулшгүй ажиллагааг бүрэн дүүрэн, шуурхай явуулж, хэргийг халуун мөрөөр нь илрүүлэхэд багаар ажиллах чадварыг нэмэгдүүлэх, бэхжүүлэх.

3.Аймгийн хэмжээнд үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн сүүлийн 5 жилийн гаралтын байдалд хийлгэж буй мэргэжлийн багийн дүн шинжилгээнд үндэслэн үр дүнтэй ажил арга хэмжээг зохион байгуулах.

4.Шинэчлэгдэн батлагдсан хуулиудыг хэрэгжүүлэх чиглэлээр тасгийн дарга, ахлах нараас тавих хяналт, алба хаагчидтай ажиллах ажиллагааг сайжруулж, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагааг шуурхай бүрэн дүүрэн, процессийн зөрчилгүй явуулах талаар эрх бүхий алба хаагчдыг дадлагажуулах, удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллах.

5.ЦЕГ-ын даргын 2018 оны А/130 дугаар тушаалаар батлагдсан Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын үйл ажиллагаа алба хаагчдын мэргэшлийн

